

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН
ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ
СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТАНД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ





НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН
ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ,
ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ
ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ,
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТАНД ХИЙСЭН
ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны баг:

Б.Анирмаа (LL.V), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн
гишүүн өмгөөлөгч

Б.Баялагмаа (LL.M), МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,
“Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгч

Б.Наранцэцэг (LL.V), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн
гишүүн өмгөөлөгч

Э.Энхцэцэг (LL.V), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн
гишүүн өмгөөлөгч

Б.Уянга (LL.V), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн хуульч

Судалгааны багт тусалсан:

М.Маралмаа, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан

Б.Мэндбаяр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан

Э.Энэрэл, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан

Улаанбаатар хот

2022 он

ННА 67.3
ДАА 340.009
Х-758



**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ
БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ
ҮЕ ШАТАНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ**

Судалгааны баг:

Б.Анирмаа (LL.B), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгч
Б.Баялагмаа (LL.M), МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш,
“Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгч
Б.Наранцэцэг (LL.B), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгч
Э.Энхцэцэг (LL.B), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн гишүүн өмгөөлөгч
Б.Уянга (LL.B), “Өмгөөллийн Фиделитас Партнерс” ХХН-ийн хуульч

Судалгааны багт тусалсан:

М.Маралмаа, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан
Б.Мэндбаяр, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан
Э.Энэрэл, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн 5-р түвшний оюутан

Тус тайлангийн үр дүн, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9812-9-7

© Нээлттэй Нийгэм Форум, 2022

Хаяг: Жамьян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240
Утас: 976-76113207
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

ӨМНӨХ ҮГ

Шинэ төрлийн коронавирусийн халдвар гарч хүн төрөлхтөн хүнд сорилттой тулгараад багагүй хугацааг өнгөрүүлж байна. Энэ цаг үед халдвар тархахаас сэргийлэх, цар тахлын дэгдэлтийг хумих үйл ажиллагааны явцад хүний эрх зөрчигдөх, хүн амын тодорхой бүлгүүд ялгаварлан гадуурхалтад өртөж байгааг бид анхаарахгүй өнгөрөх аргагүй. Тиймээс Нээлттэй Нийгэм Форум энэ үйл явцыг хөндлөнгийн хараат бус судалгаа, мониторингоор баримтжуулж, алдаа дутагдлыг засаж залруулах чиглэлээр үндэслэл бүхий дүгнэлт, санал зөвлөмж боловсруулан шийдвэр гаргагч, хэрэгжүүлэгчдэд тухай бүрд хүргүүлж ажиллахыг зорьж ирлээ.

Бид энэ хүрээнд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл боловсруулж, хэрэгжүүлэх үе шатанд хийх дүн шинжилгээг Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН-өөр гүйцэтгүүллээ. Тус дүн шинжилгээгээр бусад улс орон цар тахалтай тэмцэх эрх зүйн орчноо хэрхэн бүрдүүлж байгааг өөрийн орны энэ асуудлаарх хууль батлах үйл явцтай харьцуулан судалж, хуулийн хэрэгжилтийн шатанд гарсан хүний эрхийн зөрчил, тулгамдсан бусад асуудалд тулгуурлан санал зөвлөмж боловсрууллаа.

Түүнчлэн бид цар тахлын үеийн хөл хорио ба хүний эрх, боловсрол, төсөв, сонгууль, хууль сахиулах хүрээнд цар тахлын нөлөөг судлан, үр дүнг олон нийтэд хүргээд байна. Үүний зэрэгцээ тодорхой эрхийн хэрэгжилт, цар тахлын нөхцөл дэх хууль сахиулах ажиллагаанд тус тус хөндлөнгийн мониторинг хийхэд дэмжлэг үзүүлж байна. Дээрх судалгаа, мониторингийн үр дүнтэй танилцахыг хүсвэл Та www.forum.mn вэб сайт болон манай байгууллагын нийгмийн сүлжээнд хандаж үзэх боломжтойг дуулгахад таатай байна. Бидний судалгааны ажилд Таны өгөх санал, шүүмж онцгой үнэ цэнтэй байх болно.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

АГУУЛГА

УДИРТГАЛ	7
Нэг. Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн нэмэлт, өөрчлөлт ба олон улсын практик	9
1.1. Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох судалгаа, шинжилгээ болон хуулийн хэрэгжилтийг үнэлэхгүй байх зохицуулалтын тухайд	9
1.2. Шинэ төрлийн коронавируст халдварын үеийн харилцааг зохицуулах хууль боловсруулан баталж буй олон улсын практик	17
Хоёр. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатыг баримтлах шаардлага ба Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төсөл	30
2.1. Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн уялдаа холбоо	30
2.2. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн төслийг боловсруулахад судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг мөрдсөн эсэх	36
Гурав. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх шаардлага	39

3.1. Хуулийн хэрэгжилт ба хүний эрхийн зөрчил	39
3.2. Хууль хэрэгжүүлэх захиргааны байгууллага, албан тушаалтны чиг үүргийн давхцал	51
3.3. Захиргааны хэм хэмжээний актын эрх зүйн үйлчлэл	52
ДҮГНЭЛТ	72
САНАЛ	76
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	78

ЗУРАГ

Зураг 1. Ковидын хууль боловсруулж баталсан цаг хугацааны дараалал	16
---	----

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Цар тахлын асуудлаар тусгайлан хууль баталсан улс орнууд	21
Хүснэгт 2. Хуулийн зорилго, хамрах хүрээ, зохицуулсан асуудал	23
Хүснэгт 3. Хуулийн төсөл боловсруулж батлах ердийн процесс	24
Хүснэгт 4. Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг арга хэмжээ авах хууль боловсруулж баталсан процесс	25
Хүснэгт 5. Ердийн хуулийн төсөлд тавигдах шаардлага ба бүрдүүлбэр	26
Хүснэгт 6. Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг арга хэмжээ авах хуулийн төслийн бүрдүүлбэр хангасан байдал	28
Хүснэгт 7. Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах хугацааг журамласан байдал	45
Хүснэгт 8. Ковидын хуулиар шилжүүлсэн тусгай эрхэд үндэслэн захиргааны байгууллагаас баталсан журам, эрх зүйн бусад акт	53

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
УОК	Улсын онцгой комисс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ИБУИНВУ	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
Ковидын хууль	Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн тавдугаар бүлэгт “Хуулийн тухай хуулийг батлуулж, хуулийн хэрэгцээ шаардлага, хэрэгжилтийг үнэлдэг болох” гэж заасныг үндэслэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагааны журам тогтоох, нэгдсэн арга зүйг бий болгох зорилгоор¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан билээ. Уг хуулиар хууль бүтээх ажиллагаанд баримтлах зарчмуудыг тодорхойлсноос гадна хуулийн төсөл боловсруулах ажлын үе шат, зайлшгүй хийх судалгаа, шинжилгээг тогтоосон. Тухайлбал, хуулийн төслийн үр нөлөө болон хууль хэрэгжүүлэхэд гарах зардлыг судлахаар хуульчилсан. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах шатанд дээрх судалгаа, шинжилгээг хийх нь хууль хэрэгжихгүй байх эсхүл хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Улсын Их Хурал (УИХ)-аас 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталснаар шинэ төрлийн коронавируст халдвар (Ковид-19)-т цар тахлын үед нийгэм-эдийн засгийн тодорхой харилцааг зохицуулсан хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төсөл боловсруулахад судалгаа, шинжилгээ хийхгүйгээр шууд батлах практик тогтоосон. Улмаар цар тахлын үед батлагдсан хууль, УИХ-ын бусад шийдвэр, түүнд үндэслэсэн захиргааны байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа нь хүний эрх зөрчсөн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь уялдаа холбоогүй байснаас хуулийн үр нөлөөг бууруулж, уг хуулийн зорилго, үзэл баримтлалд тодорхойлсон үр дүнд хүрэхэд сөрөг үр дагавар бий болгожээ.

¹ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2015 он, 1 дэх тал.

Энэхүү судалгаагаар аливаа хууль судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг хууль бүтээх ажиллагаанд баримтлаагүйн улмаас үүсэж болох үр дагаврыг Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (цаашид “Ковидын хууль” гэх)-ийн төсөл боловсруулах үе шат болон хуулийн хэрэгжилтийг харьцуулан судаллаа. Түүнчлэн судлаачдын баг судалгаа, шинжилгээнд үндэслээгүй хууль боловсруулах практикийг халах санал гаргасан болно.

Хуулийн төсөл боловсруулах ажлын үе шатыг баримталсан эсэхэд дүгнэлт хийхдээ Хууль тогтоомжийн тухай хууль, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Ковидын хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулга болон эдгээр хуулийн төслийг боловсруулахад хийгдсэн судалгаа, холбогдох бичиг баримт, мэдээллийг цуглуулж, формаль-хууль зүйн арга буюу цэвэр хууль зүйн талаас нь үнэлэлт дүгнэлт хийх замаар уг судалгааг хийж гүйцэтгэлээ. Мөн бусад улс орны шинэ төрлийн коронавируст цар тахлын үеийн харилцааг зохицуулахаар баталсан хууль болон тухайн хуулийн төсөл боловсруулах процессыг эрх зүйн харьцуулсан судалгааны арга ашиглан авч үзсэн болно. Үүнд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын Улсын хэмжээний цар тахал өвчний үед хүн амыг хамгаалах тухай хууль, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс (ИБУИНВУ)-ын Коронавирусийн тухай хууль, Канад Улсын COVID-19-ийн эсрэг авсан зарим арга хэмжээг дагаж мөрдөх тухай хуулийн зохицуулалт болон хуулийн төсөл боловсруулж баталсан процесс багтана.

Мөн Ковидын хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын үед гарсан хүний эрхийн зөрчлүүдийн талаарх мэдээлэл цуглуулан анализ хийж, бусад судалгааны тайланг боловсруулах зэргээр нэлээд нухацтай авч судалсан болно.

Эдгээр асуудлыг судалсны дүнд цаашид цар тахлын нөхцөлд хуулийн төсөл боловсруулахад зайлшгүй анхаарах асуудлыг тусгасан дүгнэлт, санал боловсруулан энэхүү тайлангийн төгсгөлд оруулав.

НЭГ. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 12 ДУГААР ЗҮЙЛИЙН 2 ДАХЬ ХЭСГИЙН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БА ОЛОН УЛСЫН ПРАКТИК

1.1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ХОЛБОГДОХ СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ БОЛОН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХГҮЙ БАЙХ ЗОХИЦУУЛАЛТЫН ТУХАЙД

УИХ-аас 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр Хууль тогтоомжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдсөн билээ. Уг хуулийг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг баримтлахаар хуульчилсан.² Үүнд:

- ил тод, нээлттэй байх;
- олон нийтийн оролцоог хангах;
- ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх.

Хууль бүтээх ажиллагаанд зайлшгүй баримталбал зохих дараах зарчмуудыг Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор О.Амархүү мөн тодорхойлсон байна.³ Үүнд:

- шинжлэх ухаанч үндэслэлтэй байх;
- ардчилсан (иргэд саналаа хэлэх, бүх нийтээрээ хэлэлцүүлэхэд оролцох);

² Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга), 4 дүгээр зүйл, 2015 он.

³ Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, УБ., 2016, 16-17 дахь тал.

- хууль дээдлэх (зөвхөн хуульд заасан арга хэлбэрээр);
- нарийн систем буюу тогтолцоотой байх.

Дээрх зарчмуудаас дүгнэхэд хууль тогтоомжийг санаачлах, төсөл боловсруулахдаа шинжлэх ухаанч буюу судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх нь зайлшгүй болохыг харуулж байна. Учир нь судалгаа, шинжилгээ хийснээр тухайн харилцааг хуулиар зохицуулах хэрэгцээ, шаардлага бий эсэх, асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам юу болохыг бодитой тогтоох боломж бүрдэнэ.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шат”-ыг эрэмбэлэхдээ нэн тэргүүнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр хуульчилсан. Тус хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор хууль тогтоомжийн судалгаа, шинжилгээг гүйцэтгэхэд баримтлах дараах цогц аргачлалыг баталсан байна. Үүнд:⁴

- Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал;
- Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал;
- Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал;
- Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал;
- Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал.

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолоор баталсан.

Аливаа хууль тогтоомжийн төсөл, түүний үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулахаас өмнө дээрх аргачлалын дагуу хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалж, үр дүнг нэгтгэн зөвлөмж гаргадаг. Уг ажлын хүрээнд тухайлсан асуудлын эерэг болон сөрөг талыг харьцуулан судалсны үндсэн дээр хуулийн үр нөлөөг урьдчилан тооцож, уг асуудлыг шийдвэрлэх үр дүнтэй хувилбарыг хууль санаачлагчид санал болгоно.⁵ Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандан судалж, үр нөлөөг үнэлэн, зардлын тооцоог хийснээр бодит байдалд нийцсэн хууль боловсруулах боломж бүрдэнэ.

Гэсэн хэдий ч УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зарим хууль тогтоомжийг боловсруулахад холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэх аргачлал “хамаарахгүй” гэсэн нэмэлт орсон. Тодруулбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт жагсаасан дараах нэршил бүхий хууль, хууль тогтоомжийг боловсруулахад хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх, хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал тус тус хамаарахгүй байхаар нэмэлт оруулсан. Үүнд:⁶

1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ;
2. Тухайн жилийн улсын төсөв, төсвийн тодотгол;
3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл;
4. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр;
5. Засгийн газрын өрийн удирдлагын стратеги;

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 1.2 дахь хэсэг.

⁶ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2017, №16.

6. Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай;
7. Дайны байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, Дайн бүхий байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;
8. Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний тухай хууль;
9. Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох, чөлөөлөх;
10. Улсын Их Хурлын дотоод зохион байгуулалт, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын үйл ажиллагааны тухай тогтоол болон Улсын Их хурлын анхдугаар чуулганаар Улсын Их Хурлын дарга, дэд даргыг сонгох тухай Улсын Их Хурлын тогтоол;
11. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын төсөл батлах тухай;
12. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай;
13. Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай;
14. Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай;
15. Төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах үндсэн чиглэл батлах тухай;
16. Албан тушаалтныг томилох, чөлөөлөх тухай.

Үүний зэрэгцээ тус хуулийн нэмэлтээр дээрх хуулиудын төсөл боловсруулах үе шатанд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болохоор зохицуулсан.⁷ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын

⁷ Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 38.8 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.2-т заасан хууль тогтоомжийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно” гэсэн нэмэлт оруулсан.

14-ний өдрийн хуулийн төслийн үзэл баримтлалд⁸ дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалууд хамаарахгүйгээр боловсруулах зохицуулалтыг хуульд тусгах бөгөөд төсөвт холбогдох харилцааг Төсвийн тухай хуулиар зохицуулах нь зүйтэй гэж дүгнэсэн байна.⁹ Үүнд:

- Тухайн жилийн Төсвийн тухай хуулийн төсөл, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;
- Эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Засгийн газраас боловсруулж, УИХ-аас яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөл;
- Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөл;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсвийн гүйцэтгэл, хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэл, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, төрөөс мөнгөний талаар тухайн жилд баримтлах бодлого батлах УИХ-ын тогтоолын төсөл зэрэг болно.¹⁰

Тус хуулийн төслийн үзэл баримтлалд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл нь бодлого, төлөвлөлтийн шинжтэй баримт бичиг тул тэдгээрт тусгасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийх талаар дурдсан боловч 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн нэмэлтээр Хууль тогтоомжийн тухай хуульд Төсвийн тухай хууль, түүнд холбогдох хууль тогтоомжоос эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, бодлого, төлөвлөлтийн шинжтэй баримт бичгийг ялгаж зааглалгүйгээр хамтад нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт жагсаан оруулжээ. Ингэснээр хууль бүтээх ажиллагаа дахь судалгаа, шинжилгээний үе шатыг алгасаж батлах хууль тогтоомжийн хамрах хүрээг өргөтгөжээ.

⁸ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2017.04.14-ний өдөр батлагдсан) хуулийн төслийн үзэл баримтлал.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Мөн тэнд.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2017 онд хоёр дахь удаагаа буюу 5 дугаар сарын 12-ны өдөр баталсан. Тус хуулиар холбогдох аргачлалын дагуу судалгаа, шинжилгээ хийхийг шаардахгүй шууд боловсруулж батлах хууль тогтоомжийн жагсаалтыг улам өргөжүүлсэн байна. Үүнд:

1. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16(1).1-д заасан хууль тогтоомжийн төсөл;
2. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.1 дэх заалт (Монгол Улсын оршин тогтнохын аюулгүй байдал), 3.4.3 дахь заалт (иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал)-ын асуудлаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл;
3. Дипломат харилцаа тогтоох тухай;
4. Дипломат төлөөлөгчийн газрын түвшин, байршлыг тогтоох тухай;
5. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч батлах тухай;
6. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай;
7. Онцгой албан татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх тухай Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл;
8. Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор хэд хэдэн хуульд нэгэн зэрэг өөрчлөлт оруулахаар боловсруулсан хууль тогтоомжийн төсөл.

Хууль тогтоомжийн тухай хууль хэрэгжиж эхлэхээс өмнө 12.2 дахь хэсгийг нэмэлтээр оруулан, шууд боловсруулах хууль тогтоомжийн төслийн хамрах хүрээг Төсвийн тухай хууль, түүнд холбогдох УИХ-ын бусад шийдвэрээр хязгаарлаж байсан бол 2017 онд хоёр дахь удаагаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа зайлшгүй судалгаа, шинжилгээнд тулгуурлах шаардлагатай хуулийн төслүүдийг шууд боловсруулах буруу практикийг бэхжүүлсэн нь хүний эрхийг хязгаарласан хууль тогтоомжийг судалгаа шинжилгээнд үндэслэхгүйгээр шууд боловсруулж батлах сөрөг үр дагавар бий болгосон байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр,¹¹ 2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр,¹² 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр,¹³ 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдөр¹⁴ тус тус дөрвөн хууль баталж, нийт 25 төрлийн хууль тогтоомжийн төслийг шууд боловсруулж батлах нөхцөл бүрдүүлсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 онд хоёр удаагийн давтамжтайгаар оруулсан нэмэлт өөрчлөлтөөс гадна 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуулиар “...онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль”-ийн төслийг шууд боловсруулахаар зохицуулжээ. Хуулийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэхгүйгээр шууд боловсруулах эрх зүйн үндсийг тогтоож байгаа нь санхүү, төсвийн үр нөлөөг урьдчилан тооцож, үр дагаврыг үнэлэх ажил хангалтгүйн улмаас бодит амьдралд хэрэгжихгүй хууль баталж байгааг өөрчлөх¹⁵ зорилгоор 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр баталсан Хууль тогтоомжийн тухай хуулийн суурь үзэл баримтлал, зарчимтай нийцэхгүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.2 дахь хэсэгт судалгаа, шинжилгээ хийх аргачлал хамаарахгүй хууль тогтоомжийн төслийн хүрээг тодорхойлохдоо нийгмийн тодорхой харилцааг бүхэлд нь зохицуулах, хүний эрхийг хязгаарлах боломжтой хууль багтаасан нь иргэдийн эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх сөрөг нөлөөг бий болгосон. Тодруулбал, УИХ-ын чуулганы 2020 оны 4 дүгээр сарын

¹¹ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль, “Төрийн мэдээлэл”, сэтгүүл, 2017, №16.

¹² Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, “Төрийн мэдээлэл” сэтгүүл, 2017, №20.

¹³ Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УБ., 2020 он. <https://www.legalinfo.mn/additional/details/3722?lawid=11119>, хандалт хийсэн огноо 2021.10.15.


¹⁴ Хууль тогтоомжийн тухай хууль өөрчлөлт оруулах тухай хууль, УБ., 2020 он. <https://www.legalinfo.mn/additional/details/3779?lawid=11119>, хандалт хийсэн огноо 2021.10.15.

¹⁵ Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал (шинэчилсэн найруулга), 2 дахь тал.

9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Хууль тогтоомжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл” гэж өөрчлөн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7 дахь заалтын “заасан” гэсний дараа “... болон онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл” гэсэн нэмэлт оруулсан.¹⁶

Дээрх хуульд үндэслэн Ковидын хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12.1 дэх хэсэгт заасан аргачлалын дагуу холбогдох судалгаа, шинжилгээ хийлгүй, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулалгүйгээр баталсан байна. Тус хуулийг боловсруулж баталсан нөхцөл байдлыг цаг хугацааны дарааллаар доор авч үзлээ.

Зураг 1. Ковидын хууль боловсруулж баталсан цаг хугацааны дараалал



¹⁶ Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 2-7 дахь тал. <http://parliament.mn/files/94768>, хандалт хийсэн огноо 2021.10.15.

УИХ шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын үеийн харилцааг зохицуулах хуулийн төсөл боловсруулж батлахдаа хууль бүтээх ажиллагаа судалгаа шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг зөрчсөн байна. Ковидын хуулийн үйлчлэл 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болсон.

Харин шинэ төрлийн коронавируст халдварын нөхцөл байдал үргэлжилж байгаатай холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаар “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хууль”¹⁷-ийн төслийг танилцуулаад байна. Тус хуулийн төслийг мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасныг үндэслэн судалгаа, шинжилгээ хийх, олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үе шатыг алгасаж шууд баталж болзошгүй байна.

1.2. ШИНЭ ТӨРЛИЙН КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ҮЕИЙН ХАРИЛЦААГ ЗОХИЦУУЛАХ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАН БАТАЛЖ БҮЙ ОЛОН УЛСЫН ПРАКТИК

Дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын нөхцөл байдал нь хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тавигддаг тогтсон шаардлагыг хэрэгжүүлэхэд сорилт бий болгосон. Тодруулбал, шинэ төрлийн коронавируст халдварын тархалтыг урьдчилан таамаглах боломжгүй, тархалтаас урьдчилан сэргийлэх үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага тулгамдсан зэргээс үүдэн хууль тогтоомжийг “яаралтай” горимоор батлах шаардлага улс орнуудад үүссэн байна.

Улс орнууд Ковид-19 цар тахлын үеийн онцгой нөхцөл байдалд дараах гурван төрлийн яаралтай арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Үүнд:¹⁸

¹⁷ Монгол Улсын Сангийн сайдын 2021.09.28-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хүргүүлсэн “Санал авах тухай” албан тоот.

¹⁸ Sean Molloy, “Emergency Law Responses to Covid-19 and the Impact on Peace and Transition Processes”, 2020, p. 10.

1. Үндсэн хуулийн зохицуулалтын хүрээнд арга хэмжээ авахыг зөвшөөрөх¹⁹;
2. Онцгой нөхцөл байдалд авч хэрэгжүүлэх арга хэмжээг хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг тайлбарлах замаар авах эсвэл шинээр хууль батлах;
3. Гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгчээс тодорхой хууль зүйн үндэслэлгүйгээр арга хэмжээ авах.

Засгийн газрууд цар тахлын нөхцөл байдалд хариу үзүүлэх цогц арга хэмжээ авах, эдийн засгийн үр нөлөө бүхий бодлогын шийдвэрүүдийг хамгийн боломжит богино хугацаанд гаргах сорилттой тулгарсан. Цар тахал тойрсон олон асуудлыг хуулиар бус хууль тогтоох байгууллага эсхүл хуулиар эрх олгогдсоны дагуу Засгийн газар, түүний харьяа байгууллага, албан тушаалтны тогтоол, шийдвэр, дүрэм, журмаар зохицуулж шийдвэрлэсэн тохиолдол цөөнгүй байна. Эдгээр бодлогын зохицуулалт нь албадлага, хяналт бүхий хамгаалалтын арга хэмжээ (хөл хорионы дэглэм, аялал жуулчлалын хязгаарлалт, хориглолт, сургууль, их сургуулиудыг хаах, нийтийг хамарсан арга хэмжээг цуцлах гэх мэт), санхүүгийн хувьд (мөнгөний) чадавхжуулах, мөн эрүүл мэндийн тогтолцоо, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийг чадавхжуулах гэсэн нийтлэг төрөлд хувааж болохоор байна.

Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахалтай тэмцэх хүрээнд авч хэрэгжүүлсэн зохицуулалтын арга хэмжээг ердийн үед хэрэгжүүлдэг хугацаанаас богиносгосон тохиолдол буюу тусгайлан хууль баталсан

¹⁹ Үндсэн хуульд онц байдлын талаарх хууль зүйн статусыг тодорхойлохдоо дайн, бослого, үндэсний аюулгүй байдалд аюул учруулж буй болон байгалийн гамшиг, зарим тохиолдолд эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлыг хамааруулдаг. Тухайлбал, Мадагаскар Улс Үндсэн хуулийнхаа 61 дүгээр зүйлийг баримтлан 2020 оны 3 дугаар сарын 21-ний өдөр 14 хоногийн хугацаатай Эрүүл мэндийн онц байдал зарласан. Мөн Үндсэн хуульд онц байдал тогтоох үндэслэлд эрүүл мэндийн асуудлыг шууд нэр заан оруулаагүй боловч зохицуулалтын агуулгыг тайлбарлах замаар хамааруулж хэрэглэсэн тохиолдол Колумби Улсад гарсан. Тус улс Үндсэн хуулийнхаа 213 дугаар зүйлийн дагуу цар тахал нь нийгмийн хэв журам алдагдуулж, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах болон төрийн байгууллын тогтвортой байдалд аюул учруулж байна гэх үндэслэлээр эрүүл мэндийн онц байдалд хамааруулан авч үзсэн байна.

ихэнх улсад 1-3 хоногт хууль батлан “Хурдасгасан процесс”-ыг хэрэгжүүлжээ.²⁰

Дээр дурдсанчлан улс орнууд шинэ төрлийн коронавируст халдварт цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ авахдаа (i) тусгайлсан хууль шинээр баталж, түүнд үндэслэсэн захиргааны хэм хэмжээний актаар эсвэл (ii) цар тахлын онцгой нөхцөл байдалд Засгийн газар болон эрх бүхий байгууллагуудаас шууд хэм хэмжээ тогтоосон акт баталж зохицуулах гэсэн хоёр шийдлээс сонгон хэрэгжүүлж байна. Хууль тогтоох үйл ажиллагаа нь хэм хэмжээний акт гаргахтай харьцуулахад урт хугацаа, олон шалгуур, шаардлага, бүрдүүлбэр хангахыг шаарддаг процесс тул ихэнх улс хоёр дахь хувилбарыг сонгон зохицуулалт хийжээ.

Монгол Улсын хувьд эхний хувилбарыг сонгосон бөгөөд уг судалгаагаар энэ кэйсийг тусгайлсан хууль баталсан зарим улсын туршлагатай харьцуулан судалж, дүгнэлт хийхийг зорилоо. Улс орнууд цар тахлын нөхцөлд тусгайлсан хууль батлахдаа нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах, нийгэм, эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх эрх мэдлийг Засгийн газарт “түр хугацаанд” олгоход чиглэсэн байна. Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг хэрэгжүүлэх хариу арга хэмжээнд чиглэсэн уг хуулийг гаргахдаа цаг үеийн нөхцөл байдлаас хамааран “яаралтай” шийдвэрлэх буюу “онцгой нөхцөл байдал”-д хамаарч байгаа гэх үндэслэлээр тус хуулийн төсөл боловсруулахад тавих шаардлагыг уян хатан болгосон. Түүнчлэн хуулийн төсөлд заавал шаардах судалгаа, үнэлгээг хөнгөвчлөх; батлах процесс, хуралдаанаар хэлэлцэх хугацааг богиносгох аргуудыг ашиглажээ. Тухайлбал, цар тахлын нөхцөлд хууль тогтоомжийн төсөл боловсруулахад зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийсэн байх шалгуурыг уян хатан байлгах эсхүл энэ шалгуурыг шууд хасах чиглэлийг Шинэ Зеланд Улс, Австралийн Холбооны Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Итали Улс тус тус баримталсан бол ХБНГУ, Канад Улс, ИБУИНВУ шалгуурыг судруулсан байна.

²⁰ Тухайлбал, 2020 онд Шотланд Улсад хууль батлах бүх үе шатыг нэг өдөрт багтааж Коронавирусийн хууль баталсан (Regulatory quality and COVID-19: The use of regulatory management tools in a time of crisis, 30 September 2020, p. 7.).

Цар тахлын онцгой нөхцөл байдалд хамаарах хууль тогтоомжийг дээр дурдсаны дагуу “хурдасгасан процесс”-оор хэрхэн баталсныг харьцуулан үзэх нь ач холбогдолтой. Иймд шинэ төрлийн коронавируст халдварт цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ авах хүрээнд тусгайлан хууль батлан хэрэгжүүлсэн Монгол Улс, ИБУИНВУ, ХБНГУ болон Канад Улсын хуулийн төслийг баталсан хугацаа болон халдвар авсан тохиолдлын тоо, ердийн нөхцөлд хууль батлах процессын дараалал, бүрдүүлбэрийн шаардлагууд нь хэрхэн өөрчлөгдсөн зэрэг үзүүлэлтээр Хүснэгт 1-д харьцуулан харуулав.

Хүснэгт 1. Цар тахлын асуудлаар тусгайлан хууль баталсан улс орнууд

ХБНГУ	ИБУИНВУ	Канад Улс	Монгол Улс
Хууль баталсан огноо	2020.03.25	2020.03.25	2020.04.29
Хуулийн нэр	Улсын хэмжээний цар тахал өвчний үед хүн амыг хамгаалах тухай хууль (<i>Gesetz zum Schutz der Bevölkerung bei einer epidemischen Lage von nationaler Tragweite</i>) ²¹	Коронавирусын тухай хууль 2020 (<i>Coronavirus Act 2020</i>) ²²	Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль ²⁴
Нийт хүн амын тоо	83.24 сая	67.22 сая	3.278 сая
COVID-19 тохиолдлын тоо	181,895 (0.022%)	8,623 (0.013%)	38 (0.0012%)

²¹ [²² \[²³ \\[²⁴ \\\[21\\\]\\\(https://www.legalinfo.mn/law/details/15312, хандалт хийсэн огноо 2021.10.13.</p>
</div>
<div data-bbox=\\\)\\]\\(https://parl.ca/DocumentViewer/en/43-1/bill/C-13/royal-assent, хандалт хийсэн огноо 2021.10.12.</p>
</div>
<div data-bbox=\\)\]\(https://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/contents/enacted, хандалт хийсэн огноо: 2021.10.12.</p>
</div>
<div data-bbox=\)](https://www.bgbl.de/xaver/bgbl/start.xav?startbk=Bundesanzeiger_BGBI&jumpTo=bgbl120s2397.pdf#_bgbl__%2F%2F*%5B%40attr_id%3D%27bgbl120s2397.pdf%27%5D__1634026266218, хандалт хийсэн огноо 2021.10.12.</p>
</div>
<div data-bbox=)

Хүснэгт 1-ийн үргэлжлэл

Нас баралтын тоо	351 (0.00042%)	652 (0.00097%)	36 (0.000095%)	0 (0.000%)
Өдрийн шинэ тохиолдлын тоо	607 (0.00073%)	1,468 (0.0022%)	617 (0.0016%)	-

Тайлбар: Дээрх хүснэгтэд шинэ төрлийн коронавируст халдварын эсрэг арга хэмжээ авах хууль батлах өдрийн байдлаар Ковид-19 вирусийн халдварын тохиолдлын тоог хүн амын тоотой харьцуулан авч үзсэн болно.

Хүснэгт 2. Хуулийн зорилго, хамрах хүрээ, зохицуулсан асуудал

ХБНГУ	<p>Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын дэгдэлтийн үед Холбооны Эрүүл мэндийн яаманд тодорхой эрх мэдэл олгох, эмнэлгийн ажилтнууд (эмч, сувилагч зэрэг)-д тодорхой төрлийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх эрх олгох, тодорхой тохиолдолд хувийн мэдээлэл олж авах, боловсруулах эрхийг холбогдох албан тушаалтнуудад өгөх зэрэг зохицуулалт агуулсан.</p>
ИБУИНВУ	<p>Засгийн газарт олон нийтийг хамарсан үйл ажиллагааг зогсоох, хязгаарлах, өвчний тархалтыг хязгаарлах, эдийн засаг, эрүүл мэндийн тулгамдаж буй хүндрэлтэй асуудлыг хөнгөвчлөх зорилгоор зохицуулалт хийх арга хэмжээ авах эрх, эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл мэндийн ажилтнууд болон эдийн засгийн хүнд нөхцөлд нэрвэгдсэн хүмүүст туслах зохицуулалтын арга хэмжээ авах бүрэн эрх олгосон.</p>
Канад Улс	<p>Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын үед орлогын албан татвар, халамж, нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний санхүүжилт, эрүүл мэндийн даатгалын олговрыг нэмэгдүүлэх, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан зээлийн тухай зэрэг өргөн хүрээний асуудалд авах арга хэмжээний зохицуулалт агуулсан.</p>
Монгол Улс	<p>Засгийн газарт коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зохион байгуулалтын асуудлыг онцгой журмаар шийдвэрлэх эрх олгосон.</p>

Хүснэгт 3. Хуулийн төсөл боловсруулж батлах ердийн процесс

ХБНГУ	Хуулийн төсөл санаачилсан этгээдээс хамаарч хугацааг тодорхойлно. Холбооны Засгийн газар эсхүл Бундестаг ²⁵ -аас санаачилсан тохиолдолд 21 долоо хоног, түүнээс дээш хугацаа шаардлагатай. ²⁶
ИБУИНВУ	Хууль (билл) батлах тодорхой хугацаа байдаггүй боловч хууль хэлэлцэх үе шатуудын хоорондох ердийн дундаж интервалыг тооцвол 74 өдөр болно.
Канад Улс	Ихэнх хууль тогтоомжийн төслийг Засгийн газар боловсруулдаг. Хууль тогтоомжийн төсөлд шаардагддаг бодлогын саналыг холбогдох яамнаас Засгийн газрын хуралдаанд оруулж, Засгийн газрын холбогдох хороогоор хэлэлцэн, Засгийн газарт зөвлөмж хүргүүлдэг. Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар оруулж батлуулснаар парламентад өргөн барина. Парламентын Төлөөлөгчдийн танхим гурван удаагийн хэлэлцүүлэг хийж Сенатад шилжүүлнэ. Сенат хуулийн төслийг баталсан тохиолдолд Төлөөлөгчдийн танхимд мэдэгдэж, Хатан хаан хуулийн төсөлд зөвшөөрөл олгосноор хууль батлах үе шат дуусна. ²⁷
Монгол Улс	Хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийг УИХ-ын дарга холбогдох Байнгын хороонд шилжүүлж, Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжвэл УИХ-ын нэгдсэн хуралдаанаар оруулж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол анхны хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

²⁵ Бундестаг нь ХБНГУ-ын муж улсуудын Засгийн газрын төлөөллөөс бүрддэг Үндсэн хуулийн байгууллага бөгөөд хууль санаачлах эрхтэй.
<https://www.bundesrat.de/EN/funktionen-en/funktion-en/funktion-en-node.html>, хандалт хийсэн огноо 2021.10.27.

²⁶ <https://www.bundestag.de/en/parliament/function/legislation/passage-245704>, хандалт хийсэн огноо 2021.10.12.

²⁷ https://lop.parl.ca/About/Parliament/Education/ourcountryourparliament/html_booklet/process-passing-bill-e.html, хандалт хийсэн огноо 2021.10.12.

Хүснэгт 3-ын үргэлжлэл

Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулж дэмжсэн төслийг эцсийн хэлэлцүүлэгт Байнгын хороо бэлтгэнэ. Хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг УИХ-ын нэгдсэн хуралдаанаар оруулсны дараа эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцсийн найруулгыг дахин нэгдсэн хуралдаанд танилцуулснаар УИХ-ын дарга гарын үсэг зурж ёсчилно. Тус хувийг Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэн, Ерөнхийлөгч таван хоногийн дотор бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хориг тавих боломжтой. Ерөнхийлөгч хориг тавьсан тохиолдолд УИХ нэгдсэн чуулганаар хоригийг хүлээн авах эсэхийг эцэслэн шийднэ.

Хүснэгт 4. Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг арга хэмжээ авах хууль боловсруулж баталсан процесс

ХБНГУ

Хууль санаачлагчид Бундестагд 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр хуулийн төслийг танилцуулсан ба 3 дугаар сарын 25-ны өдөр эрүүл мэнд болон төсөв хариуцсан хороод хэлэлцүүлэг хийн, зөвлөгөө өгч, шийдвэр гаргаж дүгнэлт хийсэн. 3 дугаар сарын 26-ны өдөр хууль тогтоох тогтоолын тухай мэдэгдэл гаргаж, 3 дугаар сарын 27-ны өдөр хуулийг батлан төрийн хэвлэлд нийтлэн, 3 дугаар сарын 28-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн.

ИБУИНВУ

Эрүүл мэнд, нийгмийн халамжийн асуудал хариуцсан Төрийн нарийн бичгийн дарга Мэтт Хэнкок 2020 оны 3 дугаар сарын 19-ний өдөр танилцуулан, 3 дугаар сарын 23-ны өдөр Төлөөлөгчдийн танхим хэлэлцүүлгийн үе шатаар хэлэлцүүлж, хүлээн авсан болно. Тухайн сарын 25-ны өдөр Лордуудын танхимд хэлэлцэх үе шатанд төслийг хүлээн авч, дараа нь Хатан хаан зөвшөөрснөөр хүчин төгөлдөр болсон.

Хүснэгт 4-ийн үргэлжлэл

Канад Улс	<p>Хуулийн төслийг Төлөөлөгчдийн танхимд 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр танилцуулснаар эхний болон хоёр дахь хэлэлцүүлэгт орж хороонд очсон бөгөөд хороо нь хуулийн төслийн дүгнэлтээ ямар нэгэн нэмэлт саналгүйгээр танхимд танилцуулж, танхим нь гурав дахь хэлэлцүүлгээ өрнүүлсэн байна. Сенат нь 3 дугаар сарын 25-ны өдөр эхний, хоёр дахь, гурав дахь хэлэлцүүлгээ өрнүүлж хуулийн төслийг ямар нэгэн нэмэлт саналгүйгээр баталсан. Мөн өдрөө Хатан хааны зөвшөөрлийг авсан бөгөөд уг өдөртөө хүчин төгөлдөр болсон.</p>
Монгол Улс	<p>Хуулийн төслийг санаачлагч УИХ-ын гишүүд хуулийн төслийг 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлж, 4 дүгээр сарын 21-ний өдөр www.parliament.mn цахим хуудсанд байршуулсан. Харин олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан эсэх баримт авагдаагүй.²⁸ УИХ-аас 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хуулийг баталсан байна.</p>

Хүснэгт 5. Ердийн хуулийн төсөлд тавигдах шаардлага ба бүрдүүлбэр

ХБНГУ	<p>Шинээр боловсруулах хууль тогтоомжийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж буй этгээдэд үзүүлэх хууль зүйн болон санхүүгийн бодит үр нөлөөг үнэлсэн байх, одоогийн хууль тогтоомжийн нийцэл, зөрчилдөөн, тэдгээрийн үндэслэлийг тодорхойлно.²⁹</p>
-------	--

²⁸ Олон нийтээс хуулийн төсөлд санал авсан талаарх баримт бичиг байхгүй. <http://forum.parliament.mn/projects/10853#>, хандсан огноо 2021.12.04.

²⁹ <https://www.bmi.bund.de/EN/topics/constitution/legislation/legislation-node.html>, хандсан огноо 2021.10.14.

ИБУИНВУ	<p>Хууль зүйн асуудлын илтгэх хуудас буюу батлагдсан загвар маягтын дагуу бэлтгэсэн хуулийн төсөл болон хөндөгдөж буй бусад чухал асуудлыг нэгтгэсэн Хууль зүйн баримт бичиг, Тандан судалгаа, Хуулийн төслийн тайлбар, Эрх мэдлийн илтгэх хуудас буюу хуулийн төсөлд тусгасан эрх, бүрэн эрхийн үндэслэл болон зорилгыг тайлбарласан баримт бичиг (Засгийн газрын тайлбар)³⁰ байна.</p>
Канад Улс	<p>Засгийн газрын билл - Засгийн газар бодлогын санаачилгыг хууль тогтоох санал болгон өөрчлөх шийдвэр гаргаснаар Засгийн газрын биллийн (хуулийн) төслийг боловсруулж эхэлдэг. Дараа нь Хууль зүйн яам Засгийн газрын өгсөн зааврыг баримтлан хуулийн төсөл боловсруулна. Үүнээс гадна хуулийн төсөлд хамаарах урьдчилсан зөвлөгөө өгч, судалгаа, хяналт хийж болно. Кабинетад өргөн барих меморандум бэлтгэнэ.³¹</p>
Монгол Улс	<p>Хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан тайлан, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн тайлан, үзэл баримтлал, танилцуулга, үр нөлөөг үнэлсэн болон зардлын тооцоо хийсэн тайлан, өөрчлөлт оруулах хуулийн төсөл, иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санал байна.</p>

³⁰ Cabinet Office, Guide to Making Legislation, p. 48, July 2017. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/645652/Guide_to_Making_Legislation_Jul_2017.pdf

³¹ https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/645652/Guide_to_Making_Legislation_Jul_2017.pdf, хандсан огноо 2021.10.12.

Хүснэгт 6. Шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг арга хэмжээ авах хуулийн төслийн бүрдүүлбэр хангасан байдал

ХБНГУ	Хуулийн төслийн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийх, үнэлгээний хүндрүүлсэн бус, график үзүүлэлт түлхүү ашигласан арга, техникийг зөвшөөрсөн боловч тэдгээр нь хэрэгжүүлэх боломжтой, хэмжигдэхүйц нотолгоогоор дэмжигдэх ёстой гэсэн шаардлага тавьсан. ³²
ИБУИНВУ	Хууль зүйн асуудлын илтгэх хуудас, Тандан судалгаа, Хуулийн төслийн тайлбар, Эрх мэдлийн илтгэх хуудас (Яамны сайдад эрх шилжүүлж буйг зөвтгөсөн Засгийн газрын тайлбар) зэрэг шаардлагатай аргачлалын дагуух бичиг баримт боловсруулсан байна.
Канад Улс	Кабинетад өргөн барих меморандум, хуулийн төслийн тайлбар болон анализ, хэрэгжүүлэхтэй холбоотой зардлын анализ бэлтгэсэн байна.
Монгол Улс	Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, Хууль санаачлагчийн “Хуулийн төсөлд санал, дүгнэлт авах тухай” хуудас багтсан.

Хууль тогтоомжийн төслийн баримт бичгийн бүрдүүлбэрийн чухал бүрэлдэхүүн болсон зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг Европын Холбооны зарим улсад, тухайлбал, ХБНГУ, Нидерландын Хаант Улс, Шведийн Хаант Улс болон ИБУИНВУ-д хэдэн жилийн турш хийдэг. Мөн Европын Холбооноос шинээр хууль тогтоомж батлахаас өмнө түүний эдийн засаг, нийгэм болон хүрээлэн буй орчинд үзүүлж буй үр нөлөөг боломжтой хэмжээнд заавал үнэлсэн байхыг шаарддаг.³³ Хууль

³² ХБНГУ-ын шинээр батлах хуулийн төслийг хянах үндсэн үүрэг бүхий Үндэсний зохицуулалтын хяналтын зөвлөл (National Regulatory Control Council)-өөс энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна (Regulatory quality and COVID-19: The use of regulatory management tools in a time of crisis, p. 10, September 30, 2020).

³³ World Bank Group, Global Indicators of Regulatory Governance: Worldwide Practices of Regulatory Impact Assessments, p. 3, 2017.

тогтоох ажиллагаанд түгээмэл бөгөөд заавал хэрэглэдэг үндсэн гурван зохицуулалтын удирдлагын хэрэгсэл байдаг. Үүнд:

- 1) *Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ*³⁴: Төрөөс бодлого боловсруулахад анхаарах шаардлагатай олон асуудлыг шийдвэрлэх боломжит арга зам, тэдгээрийн үр нөлөөнд ач холбогдол өгч шалгах ажиллагаа юм. Тус үнэлгээ нь сонгон авсан зохицуулалтын арга замыг хэрэгжүүлэхэд гарах зардал, үр ашгийн талаарх тодорхой мэдээллээр хангаж, шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилготой.
- 2) *Сонирхогч бүлгийн оролцоо*: Энэ нь зохицуулалтыг сайжруулж эсхүл өргөжүүлснээр нийгмээс хүлээн зөвшөөрөх боломжтой эсэх талаарх иргэдийн болон эрх ашиг нь хөндөгдөж буй бусад этгээдийн саналыг хүлээн авч мэдээлэх ажиллагаа юм. Засгийн газарт итгэл үзүүлэхгүй байх ердийн тохиолдолд сонирхогч бүлгүүдтэй зөвлөлдсөнөөр хууль тогтоомжуудад нийтийн сайн сайхныг дээд хэмжээнд хангах зохицуулалтыг тусгахад туслах чухал үр нөлөөтэй.
- 3) *Хэрэгжилтийн үнэлгээ*: Хууль тогтоомж зорилгоо хадгалж чадаж байгаа эсэх болон зорилтуудыг хэрэгжүүлж байгаа эсэхэд үнэлэлт хийх зорилготой.³⁵

Харьцуулсан судалгаанаас дүгнэхэд улс орнуудад шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын эсрэг авах арга хэмжээний тухай хуулийн төсөл боловсруулж, хэлэлцэх үе шатуудыг ердийн хуулийн төсөл батлахаас цаг хугацааны хувьд богиносгосон нийтлэг шинж ажиглагдсан ч ердийн хуулийн төсөл боловсруулахад хийгддэг үр нөлөөний судалгаа, үнэлгээ хийх, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад нийцүүлэх, үр ашиг, зардлын тооцоо хийх зэрэг үндсэн шаардлагыг цар тахлын үеийн харилцааг зохицуулах хуулийн төсөлд “сулруулж”, уян хатан байлгах эсвэл хэвээр хадгалах замаар хэрэгжүүлснээрээ Монгол Улсаас ялгаатай байна.

³⁴ Мөн тэнд, Regulatory Impact Analysis (RIA)

³⁵ Regulatory quality and COVID-19: The use of regulatory management tools in a time of crisis, p. 4-530, September 2020.

ХОЁР. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮЕ ШАТЫГ БАРИМТЛАХ ШААРДЛАГА БА КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

2.1. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 8 ДУГААР ЗҮЙЛ БОЛОН 12 ДУГААР ЗҮЙЛИЙН ХОЁР ДАХЬ ХЭСГИЙН УЯЛДАА ХОЛБОО

Хууль санаачлагчаас УИХ-д өргөн барьсан хуулийн төсөл болон УИХ-ын бусад шийдвэрийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу боловсруулагдах ёстой билээ.

Судалгааны өмнөх бүлэгт дурдсанаар харьцуулан судалсан улс орнууд шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зорилготой тусгайлсан хуулийн төслийг “яаралтай”, “хурдасгасан” хугацаагаар батлах үед ердийн хуулийн төсөл боловсруулахад тавигдах тогтоосон шаардлагуудыг зөрчөөгүй байна. Харьцуулсан судалгаагаар хуулийн төсөл боловсруулах, батлах үед хуулийн төслийн бүрдүүлбэрийг хөнгөрүүлсэн буюу тандан судалгааны хялбаршуулсан арга ашиглах, заавал нарийн төвөгтэй үнэлгээ хийхийг шаардахгүй байхаар эсхүл бүх шаардлагыг бүрэн хангуулж баталсан байна.

Монгол Улсын хувьд ердийн хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар УИХ-д өргөн мэдүүлэхэд мөн хуулийн 40.1 дэх хэсэгт заасан дараах есөн төрлийн баримт бичиг хавсаргах бүрдүүлбэрийн шаардлагыг хуульчилсан.

- 1) Хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлэх тухай хууль санаачлагчийн албан бичиг;

- 2) Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлсэн, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийсэн тайлан;
- 3) Дагалдаж өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн төсөл;
- 4) Олон улсын гэрээ соёрхон батлах тухай хуулийн төсөлд хуульд³⁶ заасан журмын дагуу хянан баталгаажуулсан олон улсын гэрээний монгол хэлээрх орчуулга;
- 5) Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд Засгийн газрын санал, дүгнэлт;
- 6) Засгийн газрын өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төслийн тухайд хуульд заасны дагуу³⁷ санхүү, төсвийн, гадаад хэргийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бичгээр өгсөн зөвшөөрөл;
- 7) Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлсэн тохиолдолд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний зөвлөмж;
- 8) Дээрх баримт бичгийн цахим хувь;
- 9) Олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёг.

Дээрх баримт бичгүүд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хуулийн төсөл боловсруулах үе шатны хүрээнд бүрдэнэ. Мөн Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 59 дүгээр тогтоолоор хууль тогтоомжийн төсөл боловсруулахад баримтлах

³⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 34 дүгээр зүйл.

³⁷ Мөн хуулийн 20.7-20.9 дэх хэсэг.

шаардлагатай зургаан төрлийн аргачлал³⁸ баталсныг хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулахдаа баримталж мөрдөх ёстой.³⁹ Гэвч Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад тэдгээр аргачлал хамаарахгүй байхаар хуульчилсан.

Улмаар Ковидын хуулийн төсөл боловсруулах шатанд ямар ч төрлийн урьдчилсан тандан судалгаа, шинжилгээ, үнэлгээ, тооцоолол тусгайлан хийгдээгүй болох нь олон нийтэд нээлттэй байршуулсан хуулийн төслийн цахим баримт бичгийн жагсаалтаас илэрхий харагдана. Тодруулбал, УИХ-ын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар баталсан Ковидын хуулийн УИХ-д өргөн барьсан төсөлд дараах баримт бичгийг хавсаргасан байна. Үүнд⁴⁰:

1. Үзэл баримтлал;
2. Танилцуулга;
3. Харьяалах байнгын хорооны дүгнэлт;
4. Хууль санаачлагч болон байгууллагуудаас ирүүлсэн албан бичиг.

Дээрх байдлаар хуулийн төсөлд заавал хавсаргахаар хуульчилсан бүрдүүлбэрийг хангаагүй нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т “...Энэ хуулийн 12.1.2-12.1.6-д заасан аргачлал нь дараах хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй”, 12.2.7-д “...Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их

³⁸ “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”.

³⁹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг.

⁴⁰ Хавсаргасан баримтуудыг эндээс үзнэ үү.
<http://forum.parliament.mn/projects/10853#>, хандалт хийсэн огноо 2021.10.14.

Хурлын шийдвэрийн төсөл” гэж заасныг баримталсантай холбоотой гэж үзэж байна. Энэ нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл буюу хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шаттай уялдахгүй байна. Годруулбал, тус хуулиар хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шатыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- 1) Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- 2) Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж батлах;
- 3) Хууль тогтоомжийн төслийг боловсруулах;
- 4) Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоог хийх;
- 5) Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтээр хууль тогтоомжийн төслийг хэлэлцүүлж, санал авах;
- 6) Хууль тогтоомжийн төсөлд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн болон судалгааны байгууллагын саналыг авах;
- 7) Хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;
- 8) Хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.

Хуулийн дээрх зохицуулалтаас хууль тогтоомжийн төсөл боловсруулахаас өмнө заавал дамжих ёстой буюу гүйцэтгэсэн байх үе шат нь хуулийн төслийг яагаад боловсруулах шаардлагатай болсныг тодорхойлох зорилгоор хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үе шат юм. Ийнхүү тодорхойлсны үндсэн дээр тухайн хууль нь тусгайлсан ямар харилцааг зохицуулах, зохицуулах ёстой агуулгаас хэрхэн халихгүй байх, бусад

хууль тогтоомжтой хэрхэн уялдах зэрэгт хариулт өгч, улмаар хуулийн хэрэгжилтийг баталгаатай хангах үндэс суурь болно.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн агуулгыг тус хуулийн зорилгод үндэслэн дээрхээс илүү өргөн хүрээнд тайлбарлавал олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хуулийн төсөл боловсруулахад Засгийн газраас баталсан аргачлалууд “хамаарахгүй” гэснийг тэдгээрийг “огт хийхгүй” гэж ойлгох боломжгүй. Тус агуулгыг дээрх судалгаа, үнэлгээ, тооцоо, хяналт шинжилгээг гүйцэтгэхгүй байхаар заасан гэж явцууруулах бус харин аргачлалуудыг дагаж мөрдөхгүйгээр буюу илүү хялбаршуулсан, хөнгөрүүлсэн байдлаар гүйцэтгэнэ гэж ойлгож, хэрэглэх шаардлагатай.

Хууль баталж, үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд чухал хэсэг болсон зохицуулалтын үр нөлөөний судалгаа, эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй иргэд, байгууллагын санал, хэрэгжилтийн үнэлгээ хийлгүйгээр баталсан хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд байх эсэх нь эргэлзээтэй юм.

Шинээр боловсруулж буй хууль тогтоомж, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн үр нөлөө, зардал, үр ашгийг хэмжих, шалгахад ашиглагддаг зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг бодлогын системчилсэн хэрэгсэл гэж үздэг.⁴¹ Зохицуулалтын үр нөлөөний үнэлгээ хийснээр шийдвэр гаргах үйл явцад дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжийн чанар, үр нөлөө, хэрэгжилт сайжрахад чухал ач холбогдолтой.

Хууль тогтоомж нь нийгмийн харилцааны үндсэн зохицуулагч болохын хувьд “чанартай” байх шаардлагатай. Хуулийн чанар гэдэгт түүний агуулга (нийгмийн бодит байдалд нийцэх чадвар) болон хэлбэр (хууль зүйн хэлбэр)-ийн аль алинд хамаарах нийгмийн харилцааг бодитой зохицуулах шинж чанарын цогц нийлбэрийг⁴² ойлгоно. Чанартай хууль тогтвортой байдаг бөгөөд хууль боловсруулах болсон үндэслэлийг ул

⁴¹ Directorate for Public Governance and Territorial Development Regulatory Policy Division, OECD (November, 2007), Building a framework for conducting Regulatory Impact Analysis (RIA): Tools Policy-Makers, Version 1.2, p. 8.

⁴² Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016, 132 дахь тал.

суурьтай тодорхойлж, сайн боловсруулалт хийснээр тогтвортой байдал бий болгоно. Хэтэрхий яаралтай, өнгөц хандан, бодит байдлыг буруу тусгах нь уг хууль тогтоомжид олон удаа нэмэлт, өөрчлөлт орох үндэс болно.⁴³ Тухайлбал, Ковидын хууль 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсанаас хойш жил гаруй хугацаанд нийт дөрвөн удаа нэмэлт, өөрчлөлт орж, давхардсан тоогоор 95, давхардаагүй тоогоор 92 зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.⁴⁴

Монгол Улс Ковидын хуулийн төсөл боловсруулахдаа дэлхийн бусад улс оронтой адил үр нөлөөний урьдчилсан тандан судалгаа хийгээгүй үндэслэл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт оруулан, түүнийг явцуу хүрээнд ойлгож хэрэгжүүлсэнтэй холбоотой.

Цар тахлын онцгой нөхцөл байдалд цаг хугацааны хувьд яаралтай батлах, хэрэгжүүлэх шаардлага үүссэн ч хууль тогтоомжийн төсөл боловсруулахад зайлшгүй шаардлагатай суурь үнэлгээ, судалгаа, шинжилгээ, тооцооллыг Засгийн газраас баталсан нарийн төвөгтэй аргачлалыг баримтлалгүйгээр, тодорхой хэмжээнд хийх боломжтой байсан. Хууль бүтээх үе шатыг хялбаршуулж, шуурхай болгох замаар хууль батлах нь тухайн хуулийг хэрэгжүүлэх явцад гарах сөрөг үр дагавраас зайлсхийх боломж олгохгүй.

Дээрх хуулийн төслийг боловсруулахаас өмнөх үе шатанд хангасан байх үндсэн шаардлага болсон хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандах судалгааг огт хийгээгүйн улмаас иргэдийн эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдэл бүхий нөхцөл үүссэн байна.

⁴³ Т.В.Кашанина, Хууль зүйн техник, УБ., 2016, 133 дахь тал.

⁴⁴ <https://old.legalinfo.mn/additional/?lawid=15312>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

2.2. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭНД ҮНДЭСЛЭСЭН БАЙХ ЗАРЧМЫГ МӨРДСӨН ЭСЭХ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасныг үндэслэн шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх зэрэг харилцааг бүхэлд нь зохицуулж байгаа хуулийн төсөл боловсруулахад судалгаа, шинжилгээ хийсэн эсэх, олон нийтийн хэлэлцүүлгээс⁴⁵ гарсан саналыг хуулийн төсөлд тусгасан эсхүл тусгаагүй тухай тайлбар хуулийн төслийн бүрдүүлбэрт байхгүй байна. Ковидын хуулийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 8.1 дэх хэсэгт заасан хэд хэдэн судалгаа, шинжилгээний үе шатыг алгассан байгааг доор нарийвчлан авч үзлээ.

- 1) Хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагын урьдчилан тандах судалгаа болон Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгээгүй.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтаар хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах эсхүл тус хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ёстой.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасныг үндэслэн Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээс хойших харилцааг хууль санаачлагчаас шинээр хууль баталж зохицуулах шаардлагатай гэж үзэж байгаа тохиолдолд Гамшгаас хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт зайлшгүй үнэлгээ хийж, түүний үр дүнд үндэслэн бие даасан хууль батлах хэрэгцээ

⁴⁵ Хууль тогтоомжийн тухай хууль (шинэчилсэн найруулга)-ын 38.6 дахь хэсэгт заасны дагуу олон нийтийн хэлэлцүүлгээс хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн албан ёсны цахим хуудсандаа байршуулна. <http://forum.parliament.mn/projects/10853#>-д олон нийтийн хэлэлцүүлгийн саналыг оруулаагүй байна.

байгаа эсэхийг тодорхойлох хуулийн шаардлага байсан боловч үнэлгээ хийгдээгүй.

- 2) Монгол Улсын Засгийн газраас баталсан хуулийн төсөл боловсруулахад баримтлах аргачлалын дагуу үр нөлөөний үнэлгээ болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийгээгүй.

Хуулийн төсөл санаачлагч УИХ-ын гишүүн Х.Нямбаатар, Ж.Энхбаяр нарын 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 2950 тоот “Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай” албан тоотод дурдсанаар нийт 23 хуудас материал хавсаргажээ. Тэдгээрийг судалж үзвэл:

- Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, нийт 17 хуудас;
- Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төслийн үзэл баримтлал гурван хуудас;
- Танилцуулга хоёр хуудас;
- УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, Х.Нямбаатар нарын 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 2797 тоот “Хуулийн төсөлд санал дүгнэлт авах тухай” албан тоот нэг хуудас багтжээ.

Тус хуулийн төсөл боловсруулахад Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтаар тодорхойлсон хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцоо гаргаж, дүн шинжилгээ хийгээгүйн улмаас хууль хэрэгжүүлэх явцад хүний амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн зөрчил гарснаас гадна хуулийн үйлчлэх хугацааг

олон дахин сунгах, удаа дараа нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудал үүссэн. Тухайлбал, тус хуульд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр⁴⁶, 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдөр⁴⁷ тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн үйлчлэх хугацааг хоёр удаа сунгасан байна.

- 3) Хүний эрхийг хязгаарлах зохицуулалт болон хуулийн төслийн талаар олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авах хугацааг иргэн, хуулийн этгээдэд олгоогүй.

Хууль санаачлагч хуулийн төслийг 2020 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн ба үүнээс дөрөв хоногийн дараа УИХ-ын албан ёсны цахим хуудас (www.parliament.mn)-ны цахим хэлэлцүүлэг⁴⁸ хэсэгт байршуулсан. Гэсэн хэдий ч Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8-д “... мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хуулийн төсөлд олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулахгүй байж болно” гэж заасныг үндэслэн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй. Тодруулбал, хуулийг УИХ-д өргөн мэдүүлэхээс өмнө Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсэгт зааснаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэн, хуулийн этгээдээс гаргасан саналыг хуулийн төсөлд тусгах эсэхийг судалж, тухайн асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой хувилбар сонгох ажиллагааг орхигдуулсан.

Хуулийн төслийг “яаралтай” гэх нэрийн дор зайлшгүй хангах ёстой үндсэн шаардлагуудыг үл хэрэгсэн боловсруулж батлуулах нь хуульд нийцэхгүйн зэрэгцээ урьдчилан таамаглах боломжгүй хүний эрхийн зөрчил дагуулах эрсдэлтэй болох нь практикаас харагдаж байна. Иймд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хуулийн төсөл боловсруулах үе шатны дагуу судалгаа, шинжилгээг зайлшгүй хийх шаардлагатай.

⁴⁶ <https://old.legalinfo.mn/additional/details/3894?lawid=15312>, хандалт хийсэн огноо 2021.11.20.

⁴⁷ <https://old.legalinfo.mn/additional/details/3996?lawid=15312>, хандалт хийсэн огноо 2021.11.20.

⁴⁸ Уг хэсэг нь Хууль санаачлагчдын боловсруулсан хуулийн төслүүдэд иргэд, ИНБ болон сонирхлын бусад бүлгийн санал авах, нэгтгэх, тусгах, талуудад эргэн тайлагнаж харилцан мэдээлэл солилцоход зориулагдсан эргэх холбоо бүхий Хоёр талт цахим хэлэлцүүлгийн систем юм.

ГУРАВ. КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)- ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ҮНЭЛГЭЭ ХИЙХ ШААРДЛАГА

3.1. ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ БА ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨРЧИЛ

Ковидын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт зааснаар хүний эрхийг хязгаарлах шийдвэр гаргах, арга хэмжээ авах эрхийг захиргааны байгууллага, албан тушаалтанд олгосон. Эрх бүхий захиргааны байгууллага, албан тушаалтан хүний эрхийг хязгаарлах шийдвэр гаргахдаа тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1-11.1.5⁴⁹-д заасан шаардлагыг хангаж ажиллаагүйгээс дараах хүний эрхийн зөрчлүүд гарсан байна. Үүнд:

Зөрчил 1. Иргэний амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах, улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийн зөрчил

Ковидын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.19 дэх заалтад Засгийн газар улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхээр заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 194 дугаартай тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэн, аймаг, нийслэлийн хооронд

⁴⁹ Тус зүйлд 2021.01.29-ний өдөр 11.1.6 дахь заалтыг нэмж оруулсан бөгөөд Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл”-д дурдсан хүний эрхийн зөрчлүүд гарсан хугацаанд хамаарах тул ийнхүү дурдав.

Зөрчил 1-ийн үргэлжлэл

зорчих хөдөлгөөнийг хязгаарлаж, ... иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үүрэг болгосон.

Улмаар Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 12 дугаар сарын 5-ны өдрийн 113581 дугаартай албан бичгээр Эмээлтийн товчоон дээр үүрэг гүйцэтгэж байсан албан хаагчдад зөвхөн полимеразын гинжин урвал шинжилгээ (цаашид ПГУ шинжилгээ гэх⁵⁰)-гээр коронавируст халдвар илрээгүй иргэдийг товчоогоор нэвтрүүлэх тухай чиглэл ирүүлжээ. Үүний улмаас 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдрийн оройн 22 цаг орчим Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо дахь Эмээлт авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор Архангай аймгаас хүрэлцэн ирсэн долоон хүнийг нэвтрүүлээгүй. Товчоонд ирэхдээ эдгээр хүмүүсийн нэг болох 58 настай иргэн “О”-гийн биеийн байдал тааруу, эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай байсан. 12 дугаар сарын 6-ны өдөр коронавируст халдваргүй гэсэн түргэвчилсэн шинжилгээний хариу гарсан боловч ПГУ шинжилгээнд хамрагдаж чадаагүй. Тухайн үед Архангай аймагт ПГУ шинжилгээний аппарат байгаагүй”.⁵¹

Товчоонд үүрэг гүйцэтгэж байсан эмч П иргэн О-гийн биеийн байдлыг үзээд Нийслэлийн онцгой комиссын жижүүртэй холбогдож, түүнийг товчоогоор нэвтрүүлэх эсэхийг асуухад голомтын бүс болсон аймгаас ирсэн хүнийг ПГУ шинжилгээ авалгүйгээр Улаанбаатар хотод нэвтрүүлэхгүй байх чиглэл өгсөн байна.

⁵⁰ Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/269 дүгээр тушаалын тавдугаар хавсралт, “Коронавируст халдвар (Ковид-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар”.

⁵¹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 10 дахь тал.

Зөрчил 1-ийн үргэлжлэл

Гэтэл ПГУ шинжилгээний явуулын аппарат шалган нэвтрүүлэх товчоодын дунд нэг ширхэг байснаас зорчигчид нийт 10 цаг хүлээсэн ба энэ хугацаанд О-гийн бие хэд хэдэн удаа муудаж, 12 дугаар сарын 8-ны өдрийн өглөө бие нь эрс муудаж нас баржээ.⁵²

Мөн дээрх хугацаанд буюу 2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Архангай аймгаас Улаанбаатар хот руу нэвтрэхээр ирсэн 41 иргэн ПГУ шинжилгээ өгөөгүй байсан тул явуулын шинжилгээний баг ирж шинжилгээ авах хүртэл 22-ын товчоогоор нэвтрүүлэхээс татгалзжээ. Ингэхдээ хүмүүсийг автобуснаас нь огт буулгалгүй, 21 цаг болгосон байна. Иргэд автобусандаа хонож, цагдаагийн ажилтны өгсөн хувинд бие засаж байжээ.⁵³

Дээрх зөрчлүүд нь Ковидын хуулиар “хүний эрхийг хязгаарлах” тусгай эрх шилжүүлж авсан захиргааны байгууллага, албан тушаалтны ажлын уялдаа холбоогүй, төлөвлөгөөгүй байдал, зөрүүтэй шийдвэрээс шалтгаалж хүний амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учруулсны бодит жишээ юм. Хэдийгээр тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр нь “хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх”, 11.1.4-т “хүний амьд явах эрх, ...Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх” гэж заасан боловч хуулийн зохицуулалт хэрэгжээгүй байна. Энэ нь тус хуулийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх, хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлага байгаа болохыг харуулж байна.

⁵² Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 11 дэх тал.

⁵³ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 144 дэх тал.

Зөрчил 2. Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхийн зөрчил

Ковидын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д зааснаар гадаад улсаас нутаг буцах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэнийг үе шаттайгаар татан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах, 8.1.3-т ...зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээг УОК авч хэрэгжүүлэхээр хуульчилсан.

Харин тус зохион байгуулалтын хүрээнд “..2020 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Франкфурт-Улаанбаатар чиглэлийн тусгай үүргийн нислэгт коронавируст халдвар авсан болох нь шинжилгээгээр тогтоогдсон иргэн Ц-г багтаахгүй байх шийдвэрийг УОК-ын Шуурхай штабаас өгсөн чиглэлийн дагуу ХБНГУ-д суугаа Элчин сайдын яам Шуурхай ажлын хэсэг гаргасан. Иргэн Ц нь Прага дахь Элчин сайдын яамнаас бүртгэгдэж нутаг буцахаар Франкфуртын нисэх онгоцны буудалд ирсэн бөгөөд халдвар авсан болох нь явах танхимд орсны дараа ил болжээ. Онгоцны буудалд үлдсэн иргэн Ц-д Элчин сайдын яамтай холбоо барих утасны дугаарыг өгсөн боловч түүнийг эмчлүүлэх, шаардлагатай туслалцаа үзүүлэх идэвхтэй арга хэмжээг Элчин сайдын яам нэн даруй аваагүй байна”.⁵⁴

УОК-оос хуульд заасны дагуу зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх зөвшөөрөл олгох журмыг 2020 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар батлан гаргаагүй байсан. Мөн тусгай үүргийн нислэгээр өмнө нь халдвартай зорчигчийг тээвэрлэж, эх оронд нь авчирч байсан тохиолдол бий бөгөөд иргэн Ц-г ийнхүү онгоцонд суулгалгүй үлдээсэн нь иргэнийг ялгаварлан гадуурхсан үйлдэл бөгөөд УОК-ын Шуурхай штаб, Элчин сайдын яамны Шуурхай ажлын хэсэг дээрх шийдвэрийг гаргахдаа Ковидын тухай хуулийн 11.1.5-д заасан хүнийг ...бусад шинжээр нь ялгаварлан гадуурхахгүй байх шаардлагыг хангаагүй, мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасан ялгаварлан гадуурхахгүй байх зарчмыг үйл ажиллагаандаа баримтлаагүй нь харагдаж байна.

Дээрх зөрчил нь эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь Ковидын тухай хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй, үүргээ биелүүлээгүй,

⁵⁴ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 16 дахь тал.

мөн уг хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизм ажиллаагүйтэй холбогдон гарчээ.

Зөрчил 3. Халдашгүй, чөлөөтэй байх эрхийн зөрчил

Ковидын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.21 дэх заалтад коронавирусийн халдвар авсан, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, хуульд заасан аргаар таслан зогсоох арга хэмжээ авахыг Засгийн газарт үүрэг болгосон. Гэсэн хэдий ч Засгийн газраас тухайн асуудлаар арга хэмжээ аваагүй, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар холбогдох чиглэлийг цагдаагийн байгууллага, Засаг дарга болон холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад өгөөгүйн улмаас 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын эрх бүхий албан тушаалтан олон нийтэд мэдээлэл өгөхдөө гэрийн тусгаарлалтад байгаа хүмүүсийн орон байранд “гэрийн ажиглалт 14 хоног”, “тусгаарлалт 14 хоног” гэсэн бичигтэй, хууль сахиулах байгууллагын лого, таних тэмдэг бүхий наалт байрлуулах тухай танилцуулсан.⁵⁵

Ийнхүү нийслэлийн зарим дүүргийн орон сууц, Өвөрхангай, Төв, Хэнтий, Ховд зэрэг аймагт 2020 оны 12 дугаар сард дээрх наалтыг ашиглаж эхэлсэн, мөн орон нутагт халдвар авсан иргэний овог нэр, регистрийн дугаар, хаягийн мэдээллийг фейсбүүк олон нийтийн сүлжээ дэх аймгийн нэгдсэн групп, нэйж хуудсуудаар зарлах, халдвар авсан, тусгаарлалтад байгаа иргэдийг аюултай мэтээр харах, тэднийг ялгаварлан гадуурхах, нэр төрд нь халдах тохиолдол гарсан.

Дээрх зөрчлийн дараа буюу 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Ковидын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт нэмэлт оруулж, иргэний хувийн мэдээллийг хамгаалах үндсэн шаардлагыг хуульчилсан. Хууль санаачлагчаас тус хуулийн төслийг анх боловсруулахдаа хуулийн үр нөлөөг үнэлэн, холбогдох судалгааг хийгээгүйн улмаас хүний эрхийн дээрх зөрчлөөс урьдчилан сэргийлж чадаагүй байна.

⁵⁵ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 18 дахь тал.

Зөрчил 4. Мэдээлэл хайх, хүлээн авах эрхийн зөрчил

Ковидын хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, гадаад улс орноос өгч байгаа хандивыг УОК болон холбогдох асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэж, зарцуулалтыг олон нийтэд ил тод байлган, нэн шаардлагатай арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна гэжээ.

Коронавируст халдвар тархсантай холбоотой халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2020 оны хоёрдугаар сараас эхлэн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд мөнгөн болон мөнгөн бус хандивыг төрийн байгууллагуудад их хэмжээгээр өгсөн. Энэхүү хандив, тусламжийн орлого, төрөл, зарцуулалтын мэдээг хандив хүлээн авсан төрийн байгууллагууд шилэн дансаараа дамжуулан олон нийтэд тогтмол мэдээлэл үүрэгтэй. Гэтэл төрийн зарим байгууллагын шилэн дансны мэдээлэл бүрэн бус, ойлгомжгүй, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлээгүй зэрэг зөрчил гарсныг холбогдох этгээдийн гомдлоор Үндэсний аудитын газраас хянан шалгаж байна.

Шинэ төрлийн коронавирустэй тэмцэх ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж болон олон улсын байгууллагаас ирүүлж буй хандив тусламжийг хүлээн авч, зарцуулалтад хяналт тавих эрх бүхий байгууллага нь хуулийг зохих ёсоор хэрэгжүүлээгүйгээс дээрх зөрчил үүссэн.

Зөрчил 5. Монгол Улсын нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих эрхийн зөрчил

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоолоор⁵⁶ өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд заасныг үндэслэн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжүүлснээр гадаад улсаас ирсэн иргэдийг тодорхой хугацаагаар тусгаарлан ажиглах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоох, аж ахуйн нэгж, үйлчилгээний газрын үйл ажиллагааг хориглох, хязгаарлалт хийх арга хэмжээг УОК, Засаг дарга болон захиргааны бусад байгууллагаас зохион байгуулж хэрэгжүүлсэн.

Ковидын хууль батлагдахаас өмнө болон батлагдсаны дараа гадаад улсаас ирж буй иргэдийг тусгаарлан, ажиглах хугацааг нийт есөн удаа өөрчилснийг коронавирусийн батлагдсан тохиолдлын тоотой харьцуулан доорх хүснэгтэд үзүүлээ.

Хүснэгт 7. Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах хугацааг журамласан байдал

№	Захиргааны байгууллагаас гаргасан шийдвэр	Тусгаарлалтын хугацаа	Батлагдсан тохиолдлын тоо
1	Шадар сайд, УОК-ын даргын 2020.03.14-ний өдрийн Коронавируст халдварын үед иргэнийг тусгаарлах, ажиглах түр журам	- Тусгаарлах байранд ажиглах хугацаа - 14 хоног; - Гэрийн тусгаарлалтад байх хугацаа - 14 хоног.	1

⁵⁶ <https://old.legalinfo.mn/law/details/15081?lawid=15081>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

2	УОК-ын 2020.03.26-ны өдрийн 14 дүгээр хурлын шийдвэр	- Голомт бүхий гадаад улс орнуудаас захиалгат нислэгээр ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацаа - 21 хоног; - Гэрийн тусгаарлалтад байх хугацаа - 14 хоног.	11
3	УОК-ын 2020.04.09-ний өдрийн 15 дугаар хурлын шийдвэр	- Шинэ төрлийн коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хяналтыг сайжруулах зорилгоор гадаад улс орнуудаас ирсэн иргэдийг тусгаарлах байранд ажиглах хугацаа - 21 хоног; - Гэрийн тусгаарлалтад байх хугацаа - 14 хоног.	16
4	УОК-ын 2020.09.14-ний өдрийн 29 дүгээр хурлын шийдвэр (Энэ шийдвэрээс эхэлж тусгаарлалтын хугацаа буурч эхэлсэн)	- Тусгаарлах байранд ажиглах хугацаа - 21 хоног; - Гэрийн тусгаарлалтад байх хугацаа - 0 хоног.	311
5	УОК-ын 2020.12.08-ны өдрийн 38 дугаар хурлын шийдвэр. “Эрдэмтдийн зөвлөл”-ийн зөвлөмж,	- Тусгаарлах байранд мэргэжлийн байгууллагын хяналтад ажиглах хугацаа - 14 хоног;	893

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

	мэргэжлийн байгууллагын саналыг үндэслэн коронавируст халдвар бүртгэгдсэн гадаад улс орноос ирсэн эмнэлзүйн шинж тэмдэггүй иргэдийг “Ковид-19”-ийн шинжилгээнд үндэслэн тусгаарлана.	- Гэрээр (зочид буудалд) тусгаарлан ажиглах хугацаа - 7 хоног.	
6	УОК-ын даргын 2021.02.25-ны өдрийн 20 дугаар тушаалаар баталсан Тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам, Гэр (амрах байр)-т тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам	- Тусгаарлах байранд ажиглах хугацаа - 10 хоног; - Гэрээр тусгаарлах хугацаа - 4 хоног.	2,801
7	УОК-ын даргын 2021.05.07-ны өдрийн 43 дугаар тушаалын хавсралтаар баталсан Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам, Гэрийн ажиглалтын үйл ажиллагааг зохицуулах түр журам	- Тусгаарлах байранд ажиглах хугацаа - 7 хоног эсвэл тусгаарлахгүй; - Гэрээр тусгаарлах хугацаа - 7 хоног.	43,201

Хүснэгт 7-гийн үргэлжлэл

8	УОК-ын даргын 2021.06.24-ний өдрийн 51 дүгээр тушаалын хавсралтаар баталсан Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам	- Тусгаарлах байранд ажиглах хугацаа - 7 хоног эсхүл 4 хоног эсхүл тусгаарлахгүй; - Гэрээр тусгаарлах хугацаа - 7 хоног.	102,629
9	УОК-ын даргын 2021.10.12-ны өдрийн 61 дүгээр тушаал	- УОК-ын даргын 2021.06.24-ний өдрийн 51 дүгээр тушаалаар баталсан Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журмыг 2021.10.15-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсон.	328,304

Ковидын хууль батлагдахаас өмнө Монгол Улсын Шадар сайд, УОК-ын дарга нь 2020 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн иргэдийг тусгаарлах байранд болон гэрээр тусгаарлан, ажиглах хугацааг тогтоосон журам баталж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан. Мөн 2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хооронд 24,025 хүнийг гадаад улсаас татан авч, нэр бүхий 40 зочид буудалд тусгаарлан ажиглах арга хэмжээг УОК зохион байгуулсан⁵⁷ ба энэ хугацаанд тусгаарлан ажиглах хугацаа тогтоосон журмыг УОК-оос нийт таван удаа өөрчилсөн.

Харин Ковидын хуулийн 8.1.8 дахь заалт буюу цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний талаар холбогдох тушаал гаргах, дүрэм, журам, заавар, удирдамж батлах тусгай эрхийг 2020

⁵⁷ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүний шаардлага, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, 2021.

оны 12 дугаар сарын 31-ний өдөр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар⁵⁸ УОК-т олгосон байна. Эрх олгосноос хойш УОК-оос тусгаарлан ажиглах хугацаа тогтоосон журмыг 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдрийг хүртэл дахин дөрвөн удаа өөрчилсөн.

Ийнхүү УОК-оос богино хугацаанд баталсан журмаа хүчингүй болгон, олон дахин журам баталж буй нь Ковидын хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь хуульд үндэслэсэн байх, иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байна гэх шаардлагыг хэрэгжүүлээгүйн илрэл юм. Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 40.1.2 дахь заалтаар хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцоог судлан, дүн шинжилгээ хийгээгүйн улмаас тусгаарлан ажиглах хугацааг харилцан адилгүй тогтоож, өөрчилсөн гэж үзэж байна.

Гадаад улсаас ирсэн иргэдийг тусгаарлахаас гадна тодорхой газар нутагт хэсэгчилсэн хөл хорио тогтоох арга хэмжээ авчээ. Тухайлбал, Баянзүрх дүүргийн Засаг дарга 2021 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн “Хязгаарлалтын дэглэм тогтоох” тухай А/103 дугаар захирамж гарган коронавируст халдварын батлагдсан тохиолдол ихэссэн гэх үндэслэлээр тус дүүргийн 26 дугаар хорооны нутаг дэвсгэрт 3 дугаар сарын 17-ны өдрийн 06:00 цагаас 3 дугаар сарын 21-ний өдрийн 23:00 цаг хүртэл хязгаарлалтын дэглэм тогтоосон. Энэ хугацаанд дараалсан гурван ажлын өдөр багтсан бөгөөд шийдвэрийг урьдчилан мэдээлээгүйн улмаас иргэд ажлаа зохицуулах боломжгүй болж, тэдний албаны болон хувийн олон ажил, үйл ажиллагаа тасалдсан байна. Засаг дарга хэсэгчилсэн хөл хорио тогтоон, иргэний зарим эрхийг хязгаарлахдаа иргэд, аж ахуй нэгжид урьдчилан зарлахгүйгээр гэнэтийн шийдвэр гаргаж, хэрэгжүүлсэн болно.

Дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед онцгой байдлын хариу арга хэмжээ авахыг улс орнууд Засгийн газарт зөвшөөрдөг хэдий ч Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын газраас Ковид-19 цар тахлын үед улс орнуудад хандаж удирдамж гаргасан. Уг

⁵⁸ <https://old.legalinfo.mn/additional/details/3894?lawid=15312>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

удирдамжид “...халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зайлшгүй авч буй арга хэмжээний шаардлага, үндэслэл, хаана, ямар орчин нөхцөлд, хэдий хугацаагаар тусгаарлах арга хэмжээ үргэлжлэх талаар халдвар авсан, халдварын эрсдэл бүхий хүмүүс, олон нийтэд тайлбарлан таниулж, мэдээлэл өгсний дараа уг арга хэмжээг авах нь зүйтэй”⁵⁹ гэснийг анхаарах учиртай.

Зөрчил 6. Эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийн зөрчил

Ковидын хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.3 дахь заалтаар иргэн мэргэжлийн байгууллагын шаардлагын дагуу үзлэг, шинжилгээнд заавал хамрагдах үүрэгтэй бөгөөд 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтаар илрүүлэх шинжилгээ авах, сорьц цуглуулах ажлыг УОК-оос хэрэгжүүлэхээр заасан хэдий ч шинжилгээнд хамрагдах, шинжилгээ авахад төлбөр төлөх эсэхийг тодорхой зохицуулаагүй. Мөн хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалтаар Засгийн газраас цар тахлын үед хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, вакцин, эм, эмнэлгийн хэрэгслээр тэгш, хүртээмжтэй хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ гэж заасан боловч вакцин хийх, дархлаажуулалтад хамруулахтай холбоотой зохицуулалт огт тусгагдаагүй.

Харин хуульд цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээ авахтай холбоотой тушаал гаргах, дүрэм, журам, заавар, удирдамж батлах эрхийг холбогдох төрийн байгууллагуудад олгосон. Энэ хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 05/А/12 дугаартай “Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар батлах тухай” хамтарсан тушаалын 1 дүгээр заалтаар коронавируст халдвар илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, шинжилгээний жишиг үнэ тогтоохоор шийдвэрлэжээ. Тус хамтарсан тушаалаар шинжилгээг төлбөртэй авч буй нь Ковидын хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2 дахь заалтад “Цар тахлын халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй тохиолдолд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үнэ

⁵⁹ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, УБ., 2021, 20 дахь тал.

төлбөргүй авах” гэсэн заалтыг зөрчсөн буюу эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх хязгаарлагдаж байна.

3.2. ХУУЛЬ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ ЧИГ ҮҮРГИЙН ДАВХЦАЛ

Ковидын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтаар халдварын тохиолдол, тэдгээрийн хавьтлыг олж тогтоох үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүргийг УОК хэрэгжүүлэхээр, мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.18 дахь хэсэгт халдвар илэрсэн иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам батлах ажлыг Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газар болон Цагдаагийн ерөнхий газрын дарга нар хэрэгжүүлэхээр 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан.

Харин “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам”-ын⁶⁰ 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт эрх бүхий байгууллага, прокурорын байгууллагын алба хаагч нь цар тахлын халдвараар өвчилсөн, халдвар авсан байж болзошгүй сэжигтэй болон хавьталд орсон хүний овог нэр, утасны дугаар, гэрийн болон ажлын хаяг зэрэг мэдээ, мэдээллийг дараах хэлбэрээр гаргуулан авна. Үүнд:

- Иргэнээс харилцаа холбооны хэрэгслээр эсхүл биечлэн асууж тэмдэглэнэ.
- Хуулийн этгээдээс албан бичгээр эсхүл цахимаар гаргуулна.

Халдварын тохиолдол, хавьтлыг олж тогтоох үүргийг УОК, цагдаагийн, прокурорын болон эрх бүхий байгууллага зэрэг этгээдэд хүлээлгэсэн нь захиргааны байгууллагуудын чиг үүргийн давхардал үүсгэсний зэрэгцээ Ковидын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалтад тусгасан байгууллага хоорондын хамтын ажиллагааг хангах, харилцан мэдээлэл солилцох зарчимд нийцэхгүй байна.

⁶⁰ <https://old.legalinfo.mn/annex/details/11957?lawid=16622>, хандалт хийсэн огноо 2021.12.01.

Захиргааны байгууллага хоорондын чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, иргэдийн хувийн мэдээллийг төрийн байгууллагууд давхардаж цуглуулахгүй байх үүднээс хоорондын “мэдээлэл солилцох нэгдсэн систем”-тэй байх зорилгоор тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.23-т “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журмыг Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэж заасан. Гэтэл тус журам 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдөр буюу хуульд нэмэлт орсноос хойш таван сарын дараа батлагдсан байна. Энэ нь Ковидын хуульд захиргааны байгууллагын чиг үүргийг давхардуулан хуульчилснаас гадна тухайн харилцааг нарийвчлан зохицуулсан журмыг хэзээ баталж, хэрэгжүүлэх хугацааг тогтоогоогүйн улмаас хууль зөрчигдөх үр дагавар бий болгожээ.

3.3. ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭРХ ЗҮЙН ҮЙЛЧЛЭЛ

Цар тахлын онцгой нөхцөл байдлын үеийн харилцааг зохицуулах, нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргах тусгай эрхийг Ковидын хуулиар⁶¹ Засгийн газар болон захиргааны бусад байгууллагад шилжүүлжээ. Ийнхүү шилжүүлсэн эрхийг ямар байгууллага гүйцэтгэж буйг Хүснэгт 8-д харуулав.

⁶¹ Ковидын хуулийн 7-10-р зүйл.

Хүснэгт 8. Ковидын хуулиар шилжүүлсэн тусгай эрхэд үндэслэн захиргааны байгууллагаас баталсан журам, эрх зүйн бусад акт⁶²

№	Хуулиар эрх олгосон огноо	Хууль зүйн үндэслэл	Тусгай эрх шилжүүлэн авсан субъект	Батлагдсан журам, эрх зүйн бусад акт	Баталсан огноо, дугаар
1	2020.04.29	Хуулийн 7.1.1. “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр хорио цээр, хөдөлгөөний болон цагийн хязгаарлалт тогтоох, зайнаас харьцах зэрэг шаардлагатай арга хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын саналыг үндэслэн авах, тэдгээрт мөрдөх журам, зааврыг баглах”	Засгийн газар	“Коронавируст халдвар (Ковид-19)-ын тархалтын түвшнийг тогтоож, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах түр журам” ⁶³	2021.02.21 Дугаар 45

⁶² Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахтай холбогдуулан эрх бүхий байгууллага, албан тушаалтан баглан гаргасан эрх зүйн баримт бичгийн жагсаалтад үндэслэн тодорхойлов. <https://nema.gov.mn/wp-content/uploads/2021/03/%D0%9A%D0%9E%D0%92%D0%98%D0%94-19-%D0%B6%D0%B0%D0%B3%D1%81%D0%B0%D0%B0%D0%BB%D1%82.pdf>, хандалт хийсэн огноо 2021.12.05.

⁶³ <https://nema.gov.mn/wp-content/uploads/2021/02/%D0%B6%D1%83%D1%80%D0%B0%D0%BC-.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.10.

2	2020.04.29	Хуулийн 7.1.2. ⁶⁴ “Цар тахлын үед иргэний эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэмд шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх зорилгоор батлагдсан жилийн төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр төсвийн ерөнхийлөн захирагч хооронд, хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх”	Засгийн газар	“Коронавируст халдвар (COVID-19) -ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх арга хэмжээний тухай” тогтоол ⁶⁵	2020.05.06 Дугаар 168
				“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнгэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” тогтоол ⁶⁶	2020.11.18 Дугаар 183

⁶⁴ Тус заалтыг 2020.12.31-ний өдөр өөрчлөн найруулсан.

⁶⁵ <https://legalinfo.mn/mn/detail/15359>. хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁶⁶ <https://legalinfo.mn/mn/detail/15730>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

3	2020.04.29	Хуулийн 7.1.5. “Цар тахлын үед хорио цээр, хязгаарлалтын дэглэмийн улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгж, байгууллага, цалин, орлого нь тасалдсан иргэдэд зохих дэмжлэг үзүүлэх”	Засгийн газар	“Сайжруулсан шахмал түлшний талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол ⁶⁷	2020.12.02 Дугаар 200
4	2020.04.29	Хуулийн 7.1.7. “Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхийг улсын хэмжээнд болон зарим нутаг дэвсгэрийн хэмжээнд хязгаарлах”	Засгийн газар	“Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоол ⁶⁸	2020.12.13 Дугаар 211
				“Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоол ⁶⁹	2020.11.04 Дугаар 171

⁶⁷ <https://legalimfo.mn/mn/detail/15769>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁶⁸ <https://legalimfo.mn/mn/detail/15792>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁶⁹ <https://legalimfo.mn/mn/detail/15708>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

				“Халдвараас урьд- чилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” ТОГТООЛ	2021.01.04 Дугаар 2
5	2020.04.29	Хуулийн 7.1.8. ⁷⁰ “Өмчийн хэлбэр үл харгалзан бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар теле, цахим хэлбэрт шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, сургалтын болон догуур байрны төлбөрийг хөнгөлөх, дараагийн төлбөрт шилжүүлэх журам”	Засгийн газар	Засгийн газрын тогтоолоор шийдвэрлээгүй. ⁷¹	-
6	2020.04.29	Хуулийн 7.1.9. “Бүх шатны сургалтын байгууллагын үйл ажиллагааг тодорхой хугацаагаар хойшлуулсан, хязгаарласан тохиолдолд цахим эсхүл бусад хэлбэрээр зайн	Засгийн газар	“Төрийн бус өмчийн цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль,	2020.05.27 Дугаар 195

⁷⁰ Тус заалтыг 2020.12.31-нд өөрчлөн найруулж, 2021.01.29-ний өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан.

⁷¹ БСШУ-ы сайдын 2020.11.30-ны өдрийн А/165 тоот “Геле болон цахим хичээл зохион байгуулах тухай” тушаал. <https://www.meds.gov.mn/post/64776>, хандалт хийсэн огноо 2021.12.05.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

сургалтыг чанартай, хүргээмжтэй хүргэх, багш болон суралцагчийн оролцоо, түүнд тавих хяналтыг сайжруулах”	мэргэжлийн боловсрол, сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” тогтоол ⁷²
7 2020.04.29 Хуулийн төслийн 7.1.1.1. “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүргээмжтэй хангах”	Засгийн газар “Түр хороо байгуулах тухай” дугаар 29 тогтоол ⁷³

⁷² <https://legalinfo.mn/mn/detail/15418>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁷³ Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдал, цар тахлын үеийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр Засгийн газар, УОК-оос авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, ухуулан таниулах үүрэг бүхий Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хорооны бүрэлдэхүүнийг баталсан. <https://legalinfo.mn/mn/detail/16160842261841>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

8	2020.04.29	Хуулийн 7.1.12. “Цар тахлын үед орон гэргүй, нэн ядуу иргэдийг орон байр, хоол хүнс, ундны цэвэр усаар хангах, халдвараас сэргийлэх ажлыг зохион байгуулах”	Засгийн газар	“Бүх нийтийн бэлэн байдалд шилжсэн-тэй холбогдуулан авах арга хэмжээн-ий тухай” тогтоол ⁷⁴	2020.11.23 Дугаар 188
9	2020.04.29	Хуулийн 7.1.19. “Улсын хилээр нэвтрэх болон дотоодын зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд тодорхой хугацаанд хязгаарлалт хийх”	Засгийн газар	“Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөө-нийг зогсоох тухай” тогтоол	2020.10.30 Дугаар 164
				“Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээ-ний тухай” тогтоол ⁷⁵	2020.11.11 Дугаар 172
				“Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээ-ний тухай” тогтоол ⁷⁶	2020.11.29 Дугаар 195

⁷⁴ <https://legalinfo.mn/mn/detail/15749>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁷⁵ <https://legalinfo.mn/mn/detail/15731>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁷⁶ <https://legalinfo.mn/mn/detail/15743>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

		“Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай” тогтоол ⁷⁷	2020.12.30 Дугаар 239
		“Хилийн боомтын талаар авах арга хэмжээний тухай” тогтоол	2021.02.17 Дугаар 38
10	2020.04.29	Хуулийн 7.1.24. ⁷⁸ “Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шаардлагатай арга хэмжээг авч, холбогдох зардлыг шийдвэрлэх”	Засгийн газар 2020.09.30 Дугаар 124

⁷⁷ <https://legalinfo.mn/mm/detail/16147364274471>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁷⁸ Тус заалтад 2020.12.31-ний өдөр нэмэлт оруулсан.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

11	2020.12.31	Хуулийн 8.1.8. “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх хариу арга хэмжээний талаар холбогдох тушаал гаргах, дүрэм, заавар, удирдаж баглах”	УОК ⁷⁹	“Мэдээллийн систем, өгөгдлийн санд хандах эрх олгох тухай” тушаал ⁸⁰	2021.07.09 Дугаар 52
				“Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам” ⁸¹	2021.06.24 Дугаар 51
				“Хот болон орон нутаг хоорондын иргэдийн зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам” ⁸²	2021.05.19 Дугаар 46

⁷⁹ УОК - Улсын онцгой комисс гэдэг нэр томьёог Хүснэгт 8-д товчлон хэрэглэсэн болно.

⁸⁰ https://nema.gov.mn/wp-content/uploads/2021/07/viber_image_2021-07-13_17-21-24-711.jpg, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸¹ УОК-ын даргын 2021.10.12-ны өдрийн 61 дугаартай “Түр журам хүчингүй болгох тухай” тушаалаар тус журмыг хүчингүй болсонд тооцсон. https://drive.google.com/file/d/17_Rxtgto7TbH6_7YhbTnVvphLFQg1xk9/view, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸² <https://drive.google.com/file/d/1KWW'gjh24p7Ql8jhzak-IUn5gxl-uzgdU/view>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

“Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам” ⁸³	2021.05.06 Дугаар 41
“Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд нийслэл хотод тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах түр журам” ⁸⁴	2021.04.25 Дугаар 37

⁸³ <https://drive.google.com/file/d/1GillgawzgTtc8QQpCYERBm1-lh7SMCoj/view>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸⁴ <https://drive.google.com/file/d/1PRbQtpKyKNsISDZWDmгYOu4GijuSsOfz/view>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

12	<p>2020.04.19</p> <p>9.1. “Цар тахлын тохиолдол ажиглах, халдварыг илрүүлэх, оношлох, баталгаажуулах, мэдээлэх, халдварт өвчтөнийг тусгаарлах, эмчлэх зэрэг шаардлагагай бусад хариу арга хэмжээний журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн багална.”</p>	<p>Эрүүл мэндийн сайд</p>	<p>“Коронавируст халдвар (COVID-19)-ын багтагдсан болон сэжигтэй цогцсыг оршуулахад баримтлах түр заавар”⁸⁵</p>	<p>2020.08.28</p> <p>Дугаар А/412</p>
			<p>“Эрүүл мэндийн байгууллагад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын тусламж, үйлчилгээнд хэрэглэсэн нэг удаагийн хамгаалах хувцас, хэрэгслийг устгах түр заавар”⁸⁶</p>	<p>2020.11.06</p> <p>Дугаар А/510</p>

⁸⁵ <https://moh.gov.mn/uploads/files/42ca0c375436920eb9c16c4eb59c47fa4afec55f.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸⁶ <https://moh.gov.mn/uploads/files/ff2467ad23c10d26b0880530ea8ac3ab8fc38d27.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

“Коронавируст халдварын оношил-гоо, эмчилгээний түр заавар шинэч-лэн баглах тухай” ⁸⁷	2020.12.04 Дугаар А/562
“Эмнэлгийн тусламж, үйлчил-гээний зохицуу-лалтын түр журам” ⁸⁸	2021.02.10 Дугаар А/48
“Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сангаас санхүүжүүлэх полимеразын гинжин урвал (ПГУ)-ын шинжилгээнд иргэдийг хамруулах түр журам” ⁸⁹	2021.02.19 Дугаар А/59

⁸⁷ <https://moh.gov.mn/uploads/files/ba60528707b86eeac844753f7dc45764896e6359.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸⁸ <https://moh.gov.mn/uploads/files/22aca3df5e1478e08dee26f5b44b8e92baffde.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁸⁹ <https://moh.gov.mn/uploads/files/179e12a2b5be061a58c2a1c38c7dbf1bce34066c.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

“Коронавируст халдвар (КОВИД-19)-ын оношилгоо, эмчилгээний түр заавар” ⁹⁰	2021.03.07 Дугаар А/105
“Коронавируст халдвар (Ковид-19)-ын багтагдсан тохиолдлын гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх өвчтөнд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр журам” ⁹¹	2021.04.21 Дугаар А/239
“Коронавируст халдвар (Ковид-19)-ын үед нийслэлд хариу арга хэмжээг эрчимжүүлэх журам” ⁹²	2021.06.17 Дугаар А/380

⁹⁰ <https://moh.gov.mn/uploads/files/298c093df99dc984f91738e45ef3255de1deffe.pdf>; хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁹¹ <https://moh.gov.mn/uploads/files/ccd51cec84cd4f65cd185fc062096934cd74df2.pdf>; хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁹² <https://moh.gov.mn/uploads/files/2208b3206a63f2c7ccd707d8b2638f9753495c7e.pdf>; хандалт хийсэн огноо 2021.11.16.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

13	2020.04.29	Хуулийн 9.2. “Хилийн боомтоор нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх, халдварын сэжигтэй зорчигчийг илрүүлэх, тандах, тусгаарлалтад шилжүүлэх зэрэг хилийн нэвтрэх цэгт авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний журмыг мөргөжлийн хяналтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”	Шадар сайд	“Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлийг зохион байгуулах түр журам” ⁹³	2020.04.30
14	2020.04.29	Хуулийн 9.10. “Цар тахлын үед шүүгч, прокурорыг 24 цагаар ажиллуулах журмыг Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч болон Улсын ерөнхий прокурор тус тус баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.”	УДШ-ийн ерөнхий шүүгч	“Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед шүүгчийг 24 цагаар ажиллуулах журам” ⁹⁴	2020.11.19

⁹³ http://inspection.gov.mn/new/?page_id=29, хандалт хийсэн огноо 2021.11.16.

⁹⁴ http://judcouncil.mn/site/news_full/10904, хандалт хийсэн огноо 2021.11.09.

15	2020.04.29	Хуулийн 9.11. ⁹⁵ “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх болон бусад эрх бүхий байгууллагын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх зарим ажиллагааг цахимаар явуулж болох бөгөөд эдгээр байгууллага, иргэний үндсэн эрх, эрх чөлөөний баталгааг дордуулахгүйгээр өөрийн бүрэн эрхийн хүрээнд холбогдох журам баталж, хэрэгжилтийг зохион байгуулна.”	Улсын Дээд шүүх	“Гамшгаас хамгаалах 2020.11.18 өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хяналтын шатны шүүхийн ажиллах түр журам” ⁹⁶	“Гамшгаас хамгаалах 2020.11.24 Дугаар 116 Шүүхийн ерөнхий зөвлөл
----	------------	---	-----------------	---	--

⁹⁵ Тус заалтад 2021.01.29-ний өдөр нэмэлт оруулсан.

⁹⁶ <http://www.supremecourt.mn/news/549>, хандалт хийсэн огноо 2021.11.09.

⁹⁷ http://103.11.195.37/san/admin/upload_pdf/6b596298ac3077271609dcb517f15ef5.pdf, хандалт хийсэн огноо 2021.11.09.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

		Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн анхан шатны шүүхийн Шүүгчдийн зөвлөл	“Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хэргийн анхан шатны шүүхийн ажиллагаа явуулах түр журам” ⁹⁸	2020.12.03 Дугаар 1231
16	2020.04.29	Хуулийн 9.13. “Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журмыг Цагдаагийн төв байгууллага Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”.	Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран	“Цар тахлын талаар олон нийтийг төөрөгдүүлэх, илт худал мэдээлэл цахим орчинд тархахаас сэргийлэх зорилгоор цахим орчинд зохицуулалт хийх журам” ⁹⁹

⁹⁸ <https://drive.google.com/file/d/1rvQYHc2PdkfOggQrxM2GbJkZxdIpr/view>, хандалт хийсэн огноо 2021.11.09.

⁹⁹ <https://legalinfo.mn/mn/detail/15610>, хандалт хийсэн огноо 2021.11.08.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

17	2020.12.31	Хуулийн 9.18. “Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журмыг Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга хамтран багална”.	Улсын ерөнхий прокурор, Тагнуулын ерөнхий газрын болон Цагдаагийн ерөнхий газрын дарга	“Халдвар авсан иргэний хөдөлгөөнийг тогтоох зорилгоор иргэн, хуулийн этгээдээс мэдээ, мэдээлэл авах журам” ¹⁰⁰	2021.05.31 Дугаар А/72, А/63, А/151
18	2021.01.29	Хуулийн 9.23. “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журмыг Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран багалж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана”.	Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороо хамтран	“Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журам” ¹⁰¹	2021.05.21 Дугаар А/143, А/103

¹⁰⁰ <https://old.legalinfo.mn/annex/details/11957?lawid=16622>, хандалт хийсэн огноо 2021.11.08.

¹⁰¹ Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, 2021.05.26, №17. <https://police.gov.mn/resource/polisenew/File/2021/07/01/wteucstje5579qzh2/2021.05.21-%D0%90143%20%D0%90103.pdf>, хандалт хийсэн огноо 2021.11.08.

Хүснэгт 8-ын үргэлжлэл

19	2021.01.29	Хуулийн 10.10. “Цар гахлын үед банкнаас цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл болон бусад зээлийн гэрээнд өөрчлөлт оруулахтай холбоотой журмыг Монголбанк батална”.	Монгол-банкны Ерөнхий-лөгч	“Банкнаас цахим хэлбэрээр зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах түр журам” ¹⁰²	2021.04.12
----	------------	---	----------------------------	--	------------

¹⁰² https://www.mongolbank.mn/documents/A-100%20%D0%97%D0%A5%D0%A5%D0%9D%D0%91%D2%AF%D1%82%D0%B3%D1%8D%D0%B В%D0%B4%20%D0%B1%D2%AF%D1%82%D0%B3%D1%8D%D0%B3%D0%B4%D1%81%D1%8D%D0%BD_compressed.pdf, хандалт хийсэн огноо 2021.11.12.

Захиргааны байгууллага нь өөрт хуулиар олгосон тусгай эрхэд үндэслэн, нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр, байнга давтагдах үйлчлэлтэй шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт¹⁰³ гаргахад Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлэгт заасан нийтлэг журмыг баримталдаг. Мөн тус хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн шийдвэрийг Хууль зүй, дотоод хэргийн яамны нэгдсэн бүртгэлд бүртгэн, “Захиргааны хэм хэмжээний акт”-ын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ. Энэ хуулиар тогтоосон шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн шийдвэр эрх зүйн үйлчлэлгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй байхаар зохицуулсан болно.

Шинэ төрлийн коронавируст цар тахлын үед (Хүснэгт 8-д заасан) захиргааны байгууллагаас захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон шаардлагыг нийтээр, нэг мөр дагаж мөрдөхгүй байна. Ковидын хуулийн дагуу гарсан ганц л журам тус хуулийг дагаж мөрджээ. Энэ нь Цагдаагийн ерөнхий газар, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга нарын 2021 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/143/А03 тоот хамтарсан тушаалаар баталсан “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яамны нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, 2021 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн Захиргааны хэм хэмжээний актын 17 дугаар эмхэтгэлд нийтлүүлжээ. Харин цар тахлын онцгой нөхцөлд хуулиар олгогдсон тусгай эрхэд үндэслэн УОК, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамнаас баталсан журам, зааврыг Хууль зүй, дотоод хэргийн яамны нэгдсэн бүртгэлд бүртгүүлээгүй, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлээгүй¹⁰⁴ байх тул Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.3-г заасны дагуу тэдгээр нь эрх зүйн үйлчлэлгүй юм.

УОК-оос баталсан (Хүснэгт 8-д заасан) журмууд нь Ковидын хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.8 дахь заалтад үндэслэжээ. Тус заалтаар УОК-д өргөн хүрээтэй “тусгай эрх” олгосон байх бөгөөд ерөнхий зохицуулалтын

¹⁰³ Захиргааны ерөнхий хууль, УБ., 2015, 59.1 дэх хэсэг.

¹⁰⁴ Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, УБ, 2021.02.01, №04.

хүрээнд ямар ч асуудлыг шийдвэрлэх боломжтой байна. Цар тахлын онцгой нөхцөл байдалд үүссэн харилцааг яаралтай журмаар шийдвэрлэх нь чухал хэдий ч захиргааны байгууллагын шийдвэр нь Үндсэн хуульд заасан хууль дээдлэх зарчмыг баримталсан байх, Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагад нийцсэн байх нь зүй ёсны хэрэг юм. Гэвч УОК-оос дээрх ерөнхий зохицуулалтыг үндэслэн нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг батлахдаа Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон шаардлага, журам зөрчсөн нь хууль дээдлэх зарчим зөрчигдөх үндсэн шалтгаан болсон байна.

ДҮГНЭЛТ

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар зарим хууль тогтоомж боловсруулахад холбогдох судалгаа, шинжилгээг гүйцэтгэх аргачлал хамаарахгүй гэсэн нэмэлт оруулснаар “хууль тогтоомжийн төслийг шууд боловсруулах” хууль зүйн үндэслэл бүрдсэн. Хууль тогтоомжийн тухай хуульд орсон дөрвөн удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр нийт 25 төрлийн хууль тогтоомжийн төсөл боловсруулахад судалгаа, шинжилгээ хийх аргачлал хамаарахгүй буюу тухайлсан судалгааг хийж гүйцэтгэх шаардлагагүй байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7 дахь заалтад “...онц байдал, дайн бүхий болон дайны байдал, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төсөл” гэх нэмэлт оруулсан. Улмаар шинэ төрлийн коронавируст халдварт цар тахлын нөхцөл байдлын үеэр үүсэж буй тодорхой харилцааг зохицуулах хуулийн төсөл болон УИХ-ын бусад шийдвэрийг шууд боловсруулж батлах практик тогтсон нь хууль бүтээх ажиллагаа судалгаа, шинжилгээнд үндэслэгдсэн байх, олон нийтийн оролцоог хангах зарчимд нийцэхгүй байх бөгөөд иргэдийн эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх сөрөг нөлөөг бий болгожээ.

Харьцуулсан судалгаанаас үзэхэд хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлах дараалал, хугацаа улс бүрд харилцан адилгүй байгаа боловч Ковид-19 цар тахалтай тэмцэх тусгайлсан хууль батлахдаа холбогдох үе шатыг хурдасгасан нийтлэг шинж байна. Тухайлбал, ХБНГУ-д хуулийн төслийг Холбооны Засгийн газар эсхүл Бундестагаас

санаачилсан тохиолдолд 21 долоо хоног түүнээс дээш хугацаа шаардлагатай боловч “Улсын хэмжээний цар тахал өвчний үед хүн амыг хамгаалах тухай хууль”-ийг гурван өдрийн дотор баталжээ.

Мөн Ковид-19 шинэ төрлийн коронавируст цар тахлын эсрэг арга хэмжээ авах хуулийн төсөл боловсруулж, хэлэлцэх үе шатыг ердийн хуулийн төсөл батлахаас цаг хугацааны хувьд богиносгосон нийтлэг шинж ажиглагдсан ч хуулийн төсөл боловсруулах үе шатыг алгасаагүй улсууд байна. Тухайлбал, ИБУИНВУ Коронавирусийн тухай хууль батлахдаа Хүний эрхийн меморандум, Тандан судалгаа, Хуулийн төслийн тайлбар, Эрх мэдлийн меморандум зэрэг хуулийн төслийн бүрдүүлбэр баримт бичгүүдийг шаардлагатай аргачлалын дагуу боловсруулсан байна.

Ердийн үед хуулийн төсөл боловсруулахад хийгдсэн байх үр нөлөөний судалгаа, үнэлгээ, хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиудад нийцүүлэх, үр ашиг, зардлын тооцоо хийх зэрэг үндсэн шаардлагыг цар тахлын харилцааг зохицуулах хуулийн төсөлд “сулруулж”, тандан судалгааны хялбаршуулсан арга ашиглах, заавал нарийн төвөгтэй үнэлгээ хийхийг шаардаагүй улсууд байна. Тухайлбал, ХБНГУ-д “Улсын хэмжээний цар тахал өвчний үед хүн амыг хамгаалах тухай хууль”-ийн төслийн зохицуулалтын үр нөлөөний үнэлгээг хялбаршуулсан байдлаар хийх, үнэлгээний хүндрүүлсэн бус, график үзүүлэлт түлхүү ашигласан арга, техникийг зөвшөөрсөн боловч тэдгээр нь хэрэгжүүлэх боломжтой, хэмжигдэхүйц нотолгоонуудаар дэмжигдэх ёстой гэсэн шаардлага тавьсан нь судалгаа, шинжилгээг орхигдуулах ёсгүйн илэрхийлэл болж байна.

Монгол Улсад Ковидын хуулийн төсөл боловсруулахад урьдчилсан тандан судалгаа, шинжилгээ, үр нөлөөний үнэлгээ, эдийн засгийн тооцоолол хийгдээгүй. Тус хуулийн төсөл боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг баримталсан нь хууль тогтоомжийн чанарыг сайжруулах зорилго болон олон нийтийн оролцоог хангах, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэх зарчимд нийцэхгүй байна.

Ковидын хуулиар “хүний эрхийг хязгаарлах” эрх шилжүүлж авсан захиргааны байгууллага, албан тушаалтны бодит нөхцөлд нийцээгүй,

хоорондоо уялдаа холбоогүй, зөрүүтэй шийдвэрээс шалтгаалж хүний амь нас, аюулгүй байдал, эрүүл мэндэд хохирол учирсан. Хэдийгээр тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр нь хүний бусад үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах зорилготой байх, 11.1.4 дэх заалтаар хүний амьд явах эрх, ...Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг хөндөөгүй байх гэж заасан боловч хуулийн холбогдох заалт зөрчигдсөн.

Дээрх зөрчлүүд нь эрх бүхий байгууллага, албан тушаалтан Ковидын хуульд заасан журам батлах үүргээ биелүүлээгүй, мөн хуулийн хэрэгжилтэд хяналт тавих механизм ажиллаагүйн улмаас гарчээ. Тодруулбал, Ковидын хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт УИХ-аас энэ хуулийн биелэлтэд хяналт тавих үүрэг бүхий түр хороог УИХ-ын бүх Байнгын хорооны болон УИХ дахь цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулна, Түр хороо¹⁰⁵ нь хуулийн биелэлтийг сар тутам нээлттэйгээр хэлэлцэж, бусад Байнгын хороогоор энэ хуулийн биелэлтийг хэлэлцүүлэх санал гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж заасан.

Хэдий тийм боловч Ковидын хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор цар тахлын онцгой нөхцөлд хүний эрх зөрчигдөж байгаа нь Түр хорооноос хуулийн биелэлтэд хяналт тавих, сар тутам нээлттэйгээр хэлэлцэх үүргийг зохих ёсоор биелүүлээгүй, улмаар хуулийн хэрэгжилтийг хянах чиг үүргийн хүрээнд хүний эрхийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулаагүйтэй холбоотой юм. Үүнээс гадна Ковидын хуулиар тусгайлан эрх олгогдоогүй захиргааны байгууллага, албан тушаалтнаас нийтээр заавал дагаж мөрдөх, эрх зүйн үр дагавартай шийдвэр баталж, хүний эрхийг хязгаарлах арга хэмжээ авсан нь хүний эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах зарчим зөрчигдөх үндэслэл болжээ.

¹⁰⁵ Түр хороог анх УИХ-ын 2020.05.13-ны өдрийн 49 дүгээр тогтоолоор байгуулсан. <https://legalinfo.mn/mn/detail/15393>. Түр хорооны бүрэлдэхүүнийг УИХ-ын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 31 дүгээр тогтоолоор шинэчилсэн байна. <https://legalinfo.mn/mn/detail/15702>, хандалт хийсэн огноо 2021.11.27.

Шинэ төрлийн коронавируст цар тахлын үед захиргааны байгууллагаас гаргасан журам, заавар, бусад шийдвэр нь эрх зүйн үйлчлэлгүй буюу Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон захиргааны хэм хэмжээний актад тавигдах хууль зүйн шаардлагыг хангахгүй байна. Тухайлбал, Ковидын хуулиар олгогдсон тусгай эрхэд үндэслэн УОК, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яамнаас баталсан журам, заавруудыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлээгүй, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлээгүй¹⁰⁶ байгаа нь эдгээр шийдвэрийн хүчин төгөлдөр байдал буюу заавал биелэгдэх шинжийг алдагдуулсан байна. Дээрхээс гадна Ковидын хуулиар захиргааны байгууллагуудад цар тахлын онцгой нөхцөлд үүсэж буй харилцааг зохицуулах тусгай эрхийг шилжүүлсэн боловч холбогдох захиргааны байгууллагууд нь тухайн нөхцөл, хугацаанд тохируулан нэн даруй дүрэм, журам батлаагүй, хожимдуулан баталсан зөрчлүүд гарчээ.

¹⁰⁶ Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл, УБ., 2021.02.01, №04.

САНАЛ

- 1) Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эдийн засгийг дэмжих зорилгоор боловсруулж буй аливаа хуулийн төсөл боловсруулах ажиллагаанд судалгаа, шинжилгээнд үндэслэсэн, олон нийтийн оролцоог хангасан байх зарчмуудыг баримтлан, хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан үе шатыг баримтлан боловсруулах;
- 2) Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.7-д “...Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн, олон улсын хөл хориот өвчин гарсан онцгой нөхцөлийн хугацаанд хууль санаачлагчаас тухайн нөхцөлийг арилгах, түүнийг даван туулахтай холбоотой санаачилсан хууль” гэж заасныг хүчингүй болгох. Эсхүл хуулийн төсөл боловсруулахад баримтлах Засгийн газраас баталсан аргачлалыг 12.2.7-д заасан хуулийн төсөл боловсруулахад зориулан хялбаршуулж батлах;
- 3) Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үеийн эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлэх тухай хуулийн төсөл нь урт хугацаанд хэрэгжихээр байгаа тул яаравчилсан горимоор бус, Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйл, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасныг баримтлан холбогдох судалгаа шинжилгээ хийн, олон нийтийн оролцоог хангах замаар боловсруулж батлах;
- 4) Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-г жагсаан заасан хууль, тогтоомжийн хамрах хүрээг хумьж, хүний эрхийг хязгаарласан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах тохиолдолд холбогдох аргачлалын дагуу

судалгаа, шинжилгээг заавал хийх, олон нийтийн оролцоог хангах тухай журмыг хуульд тусгах;

- 5) Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл шинэчлэн найруулах шаардлагатай эсэхийг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, гарсан зөвлөмж, үр дүнд үндэслэн шийдвэрлэх;
- 6) Хууль санаачлагч хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулахдаа Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хуулийн төсөл боловсруулах үе шатыг чанд баримтлах;
- 7) Цар тахлын онцгой нөхцөлд захиргааны байгууллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргаж буй шийдвэрүүд нь хуульд үндэслэгдсэн байх буюу зөвхөн хуулиар тусгайлан олгогдсон эрхийн хүрээнд гарсан эсэх, Захиргааны ерөнхий хуулиар тогтоосон захиргааны хэм хэмжээний актад тавигдах шаардлагыг бүрэн хангасан эсэхэд хяналт тавих чиг үүргээ Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлэх;
- 8) Хуулийн хэрэгжилтэд таниулах, сурталчлах асуудал чухал бөгөөд хуульд заасны дагуу эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах төрийн албан хаагчдад хуулийн үндсэн зорилго, анхаарах хууль зүйн асуудлаар мэдээлэл өгөх, мэдлэгийг нэмэгдүүлэх сургалт зохион байгуулах;
- 9) Хуулийн хэрэгжилттэй холбоотой хүний эрхийн зөрчлүүд багагүй гарсан нь Түр хорооноос хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлээгүй, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх ажил зохион байгуулаагүйтэй холбоотой тул Түр хорооноос хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, хорооны үйл ажиллагаанд иргэний нийгмийн хяналтыг хэрэгжүүлэх хууль зүйн боломж бүрдүүлэх.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

А. Монгол хэлээр:

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.01.13.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015.05.29.
3. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2017.04.14.
4. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2017.05.12.
5. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2020.04.09.
6. Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, 2020.04.29.
7. Монгол Улсын Засгийн газрын “Аргачлал батлах тухай” 2016 оны 59 дүгээр тогтоол.
8. Монгол Улсын Засгийн газрын 2021.02.21-ний өдрийн “Журам батлах тухай” тогтоол.
9. Монгол Улсын Засгийн газрын 2020.09.30-ны өдрийн “Журам батлах, хөрөнгө гаргах тухай” тогтоол.
10. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн “Түр хороог байгуулж, бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” 31 дүгээр тогтоол.
11. Эрүүл мэндийн сайдын 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн А/269 дүгээр тушаалын тавдугаар хавсралтаар баталсан “Коронавируст халдвар (Ковид-19)-ын лабораторийн оношилгооны түр заавар”.
12. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020.11.30-ны өдрийн А/165 дугаар тушаал.
13. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021.01.18-ны өдрийн А/11 дугаар тушаал.
14. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/48 дугаар тушаал.

15. Монгол Улсын Шадар сайд, УОК-ын даргын 2020.03.04-ний өдрийн “Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын тээвэрлэлтийн ажиллагааг онцгой нөхцөл байдалд зохион байгуулах түр журам”.
16. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.02.19-ний өдрийн А/59 дүгээр тушаал.
17. Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2021.06.17-ны өдрийн А/380 дугаар тушаал.
18. УОК-ын даргын 2021.02.28-ны өдрийн “Түр журам батлах тухай” 21 дүгээр тушаал.
19. УОК-ын даргын 2021.02.22-ны өдрийн “Түр журам батлах тухай” 18 дугаар тушаал.
20. Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам.
21. ЦЕГ, ХХЗХ-ны дарга нарын 2020.08.27-ны өдрийн “Журам батлах тухай” хамтарсан тушаал.
22. УЕП, ТЕГ, ЦЕГ-ын дарга нарын 2021.05.31-ний өдрийн А/51 тоот “Журам батлах тухай” хамтарсан тушаал.
23. ЦЕГ, ХХЗХ-ны дарга нарын 2021.05.21-ний өдрийн А/143/103 тоот “Журам батлах тухай” хамтарсан тушаал.
24. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021.04.12-ны өдрийн А-100 дугаар “Журам батлах тухай” тушаал.
25. Хууль тогтоомжийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийн төслийн үзэл баримтлал (шинэчилсэн найруулга), 2015.
26. Д.Лүндээжанцан “Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник”, УБ., 2016.
27. Т.В.Кашанина, “Хууль зүйн техник”, УБ., 2016.
28. Хүний эрхийн Үндэсний комиссоос гаргасан “Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 20 дахь илтгэл, 2021.
29. Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 09-ний өдрийн нэгдсэн хуралдааны тэмдэглэл, 2-7 дахь тал.
30. Монгол Улсын Сангийн сайдын 2021.09.28-ны өдрийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд З.Мэндсайханд хүргүүлсэн “Санал авах тухай” албан тоот.

Б. Гадаад хэлээр:

1. Sean Molloy, *Emergency Law Responses to Covid-19 and the Impact on Peace and Transition Processes*, 2020, p. 10.
2. World Bank Group, *Global Indicators of Regulatory Governance Practices of Regulatory Impact Assessments*, p. 3.
3. *Regulatory Impact Analysis (RIA)*.
4. *Regulatory quality and COVID-19: The use of regulatory management tools in a time of crisis*, 30 September 2020, pp. 4-5.
5. Directorate for Public Governance and Territorial Development Regulatory Policy Division, OECD (November, 2007), *Building a framework for conducting Regulatory Impact Analysis (RIA): Tools Policy-Makers*, Version 1.2, p. 8.
6. Bundesanzeiger Verlag. https://www.bgbl.de/xaver/bgbl/start.xav?startbk=Bundesanzeiger_BGBl&jumpTo=bgbl120s2397.pdf#__bgbl__%2F%2F*%5B%40attr_id%3D%27bgbl120s2397.pdf%27%5D__1634026266218
7. Coronavirus Act, 2020, UK. <https://www.legislation.gov.uk/ukpga/2020/7/contents/enacted>
8. An Act respecting certain measures in response to COVID-19 Canada. <https://parl.ca/DocumentViewer/en/43-1/bill/C-13/royal-assent>;
9. Bundesrat. <https://www.bundesrat.de/EN/funktionen-en/funktion-en/funktion-en-node.html>
10. Deutscher Bundestag. <https://www.bundestag.de/en/parliament/function/legislation/passage-245704>
11. The Process of passing Bill. https://lop.parl.ca/About/Parliament/Education/ourcountryourparliament/html_booklet/process-passing-bill-e.html
12. German Legislative Process. <https://www.bmi.bund.de/EN/topics/constitution/legislation/legislation-node.html>
13. Cabinet Office, Guide to Making Legislation, Page 48, July 2017. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/645652/Guide_to_Making_Legislation_Jul_2017.pdf
14. https://assets.publishing.service.gov.uk/government/uploads/system/uploads/attachment_data/file/645652/Guide_to_Making_Legislation_Jul_2017.pdf, 2021.10.12.

КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТЭМЦЭХ,
НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ТУХАЙ



ISBN 978-9919-9812-9-7



9 789919 981297